

**Төсөл 1**

**“Монгол төмс” төсөл**

**2-р үе шатны санал**

2008 оны 1-р сарын 1-нээс 2011 оны 12-р сарын 31 хүртэл

**Швейцарийн Хөгжлийн Агентлаг,  
Монгол улсын Засгийн Газар-т**

**2007 оны 6-р сарын 8**

## Гарчиг

|  |           |
|--|-----------|
| <b>1. Үндэслэл</b> .....   | <b>3</b>  |
| 1.1. Хөгжлийн асуудлууд.....                                       | 3         |
| 1.2. Холбогдох асуудлууд.....                                      | 4         |
| 1.3. Монголын төмсний салбарын үйл ажиллагаа .....                 | 7         |
| 1.4. Төслийн хүрсэн үр дүн ба 2-р үе шатны бэлтгэл ажил .....      | 11        |
| <b>2. “Монгол төмс” төслийн санал-2-р үе шат</b> .....             | <b>16</b> |
| 2.1. Зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн.....                    | 16        |
| 2.2. Ойлголтын хүрээ, хөндлөнгийн оролцооны стратеги.....          | 17        |
| 2.3. Үйл ажиллагааны логик цар хүрээ .....                         | 18        |
| 2.4. Түншүүдийн стратегитай хамааралтай болон нийцтэй байдал ..... | 25        |
| 2.5. Бүтээгдэхүүн, үйл ажиллагаа .....                             | 30        |
| 2.6. Стратегийн зарчмууд .....                                     | 39        |
| 2.7. Хэрэгжүүлэх зарчмууд .....                                    | 41        |
| 2.8. Гол оролцогч талууд .....                                     | 43        |
| 2.9. Төслийн хугацаа, газарзүйн онцлог.....                        | 48        |
| <b>3. Эрсдэл ба таамаглал</b> .....                                | <b>49</b> |
| <b>4. Төгсгөлийн шатны стратеги</b> .....                          | <b>51</b> |
| <b>5. Төслийн зохион байгуулалт, менежмент</b> .....               | <b>51</b> |
| 5.1. Гэрээ .....   | 51        |
| 5.2. Зохицуулах хороо.....   | 51        |
| 5.3. Төслийн хэрэгжилт, менежмент.....                             | 53        |
| <b>6. Мониторинг ба үнэлгээ</b> .....                              | <b>55</b> |
| 6.1. Мониторинг.....   | 55        |
| 6.2. Үнэлгээ .....   | 56        |
| <b>7. Түншүүдийн хувь нэмэр, төслийн төсөв</b> .....               | <b>59</b> |
| 7.1. Үндэсний нөөц ба түншүүдийн оруулах хувь нэмэр .....          | 59        |
| 7.2. Төслийн төсөв .....   | 61        |
| <b>8. Лавлагаа</b> .....   | <b>61</b> |

## 1. Үндэслэл

## 1.1. Хөгжлийн асуудлууд

Байгаль, экологийн хатуу ширүүн нөхцөл, хөдөөгийн дэд бүтцийн сул дорой хөгжлөөс болоод Монголын хөдөөгийн хүн ам зөвхөн мал аж ахуй эрхлэх замаар л амьдралаа залгуулдаг бөгөөд төмс ногоо тариалах замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал юм.

Мал аж ахуй нь хөдөөгийн нийт хүн амын бараг тал хувийнх нь орлогын гол эх үүсвэр болдог бөгөөд ДНБ-ий 20%-ийг мал аж ахуйгаас олдог.

Мал аж ахуй эрхлэхээс өөр орлогын эх үүсвэр олох гол сонголт нь бага хэмжээний талбайд төмс, хүнсний ногоо тариалах явдал бөгөөд энэ нь өрхийн хүнсний аюулгүй байдлыг хангахад ихээхэн үүрэгтэй. Монгол улсын гурав дахь гол хүнсний бүтээгдэхүүн нь төмс юм. Төмс, хүнсний ногоо тариалдаг өрхийн тоо 1997 онд цөөн хэдэн зуугаар тоологдож байсан бол 2004 онд 100000 гаруй болж өссөний ихэнх нь төмс тариалсан байна. Мөн төмс, хүнсний ногоо тариалах боломжийг бүрдүүлэхийн тулд Монгол улсын Газрын хуульд 0.5га хүртэлх тариалангийн талбайг иргэдэд гэр бүлийн хэрэгцээнд нь зориулж өмчлүүлэхээр заасан байдаг. Гэхдээ энэ хэмжээ нь нийслэл, аймаг, сумын төвд ялгавартай.

Монгол улс нь зах зээлийн эдийн засагт шилжихээс өмнө Орос руу төмс экспортлодог байсан. Улсын том аж ахуйнууд задран унасантай холбоотойгоор сүүлийн жилүүдэд ургацын хэмжээ 5.6-9.3тн/га болтлоо буурч төмсний үйлдвэрлэл эрс багасчээ (Зураг 1). Монгол улсын Засгийн газраас төмсний салбарыг дэмжих асуудлыг өнөөгийн үйл ажиллагааны хөтөлбөртөө (Засгийн газар, 2004) тусгаж, төмсний салбарыг сэргээн сайжруулах донор байгууллагуудыг дэмжих бодлого барьж байна.

ШХА болон бусад байгууллагууд эхний шатны судалгааг явуулж, чанар сайтай үр хүрэлцээгүй, төмс тариалагчдын ур чадвар хангалтгүй, оновчтой технологи (ялангуяа усжуулалт, зоорь/хадгалалт, менежмент-ийн хувьд) дутагдалтай байгаа нь төмсний үйлдвэрлэлийн бүтээмжийг хязгаарлах гол хүчин зүйл болж байна гэж үзсэн.

Үүний зэрэгцээ Монголд хэрэгжиж буй донор төслүүд энэ салбарт оролцож ажиллах нь цөөн, энэ асуудалд ихэвчлэн хөндлөнгийн ажиглагчийн байр сууринаас хандаж байгаа юм. 1997-1998 онд Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Өрхийн тариалангийн төсөл 1997-1998 онд Дарханы УГТСЭШХ-д лаборатори болон хүлэмжийн нөхцөлд эрүүл үрийн үйлдвэрлэл явуулахад дэмжлэг үзүүлж байсан боловч талбайд үржүүлэг хийх тал дээр төдийлөн анхаарал хандуулаагүй. Түүнээс хойш төмсний үрийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага гарч ирээгүй.

Монгол дахь ШХА нь 2004 оноос Монгол орны агро-экологийн нөхцөлд дасан зохицсон сортуудын чанар сайтай үр үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх санаачлага гарган үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

“Монголын төмсний салбарыг сэргээн сайжруулах хөтөлбөр”-ийн зорилго нь төмсний үр үйлдвэрлэлийг үр ашигтай, тогтвортой болгон хөгжүүлж, үрийн хангалтын системийг төвлөрлөөс гаргаж, сайн чанарын үрийн хүрэлцээ хангамжийг сайжруулах замаар төмс үйлдвэрлэлийн үр ашгийг үндэсний болон орон нутгийн түвшинд тэгш сайжруулахад туслах явдал юм.

Энэхүү санаачлага дээр үндэслэн төмсний гурван шинэ сортыг, Монгол орны нөхцөлд ирээдүйтэй сортоор сонгон авч, эдгээр сортуудын үрийн үйлдвэрлэлийг явуулж байна.

Одоогийн байдлаар 2 шинэ сортын анхдагч үрийн аж ахуйг дадлага туршлагатай албан бус үр үржүүлэгчид эрхэлж байгаа бөгөөд эдгээр сортуудын үрийн хэрэгцээ маш өндөр байна.

Төслийн 2-р үе шатыг эдгээр ололт амжилтууд дээр үндэслэн хэрэгжүүлэх юм. Энэхүү санал нь үрийн аж ахуйн тогтолцоог оновчтой, тогтвортой болгох, жижиг фермерүүд үрийг хамгийн үр ашигтай ашиглаж болох стратегийг тодорхойлох, үйлдвэрлэлийн аргуудаас экологийн хувьд ээлтэй, шилдэг аргыг судалж, сонгон илрүүлэх асуудлуудыг багтаана.

Эдгээр гурван гол санаа нь төмсний үйлдвэрлэлийн үр өгөөж, ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Төмсний хангалтын сүлжээг сайжруулах шинэ үйл ажиллагаа нь хэрэглээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарын сайжруулах асуудлуудыг багтааж байна. Төслийн гол зорилго нь хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний тэжээллэг чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулах, хөдөөгийн ялангуяа хүн амын ядуу хэсгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд оршино.

Үүгээрээ ШХА нь Монгол орны хөгжлийн нэн тэргүүний асуудал болоод байгаа ядуу, эмзэг амьдралтай иргэдийн аж амьдралыг сайжруулах зорилготой гэдгээ харуулж байгаа юм.

## **1.2. Холбогдох асуудлууд**

Монгол улс нь Хятад, Орос гүрний дунд оршдог, далайд гарцгүй орон бөгөөд 1,56 сая хавтгай дөрвөлжин метр газар нутагтай, 2,6 сая хүн амтай (2006 оны 12-р сарын байдлаар). Монгол улс нь үйлдвэр, дэд бүтцийн хөгжил муу, уламжлалт бэлчээрийн мал ахуйд тулгуурласан эдийн засаг нь байгалийн нөөцөөс шууд хамааралтай. 2006 онд ДНБ 3200.0 тэрбум төгрөгт хүрч, (2.8 тэрбум \$) өсөлт нь 8.4%-аар нэмэгдсэн байна. Инфляцийн түвшин 2005 онтой харьцуулахад 9.2%-аас 5.3% болтлоо буурчээ. Энэ онд нэг хүнд ноогдох ДНБ 1000\$ хүрсэн.

### **1.2.1. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл**

Монгол улс нь бодлого, зохицуулалтын оновчтой хувилбарыг харьцангуй эрт сонгож, зах зээлийн шинэчлэл хийж, ардчилсан улс төрийн системд амжилттай шилжсэнээрээ бусад шилжилтийн шатанд байгаа улс орнуудаас харьцангуй хурдан шинэчлэлт хийж чадсан боловч ядуурлын түвшин 36% орчимтой байгаа нь (1998, 2003 оны судалгаагаар) социализмын үед ажиллах хүчний хуваарилалт, зохион байгуулалтыг хангаж байсан бараг бүх хоёрдогч салбарууд задран унасантай холбоотой.

1999-2002 онуудад тохиолдсон ган, зудын уршгаар хэдэн жилийн хугацаанд дөнгөж өсөж эхэлж байсан эдийн засагт дахин том цохилт учирсан байна. Энэ үед мал сүргийн тоо толгой 34 саяас 24 сая болж буурсан нь эдийн засгийг дахин уналтанд оруулж, 800000 орчим хүний аж амьдрал нь мал аж ахуйгаас шууд ба шууд бус хамааралтай бөгөөд байгаль орчны өөрчлөлтөнд мэдрэмтгий болохыг тодорхой харуулсан юм.

Хөдөөд ядуурал хот суурин газрынхаас харьцангуй өндөр байгаа бөгөөд (43% ба 30%) ялангуяа малчид хөдөөгийн хүн амын хамгийн ядуу хэсэг хэвээр байна. Гэхдээ ядуурал Монгол орны бүс нутгуудад харилцан адилгүй ялгаатай байгаа бөгөөд Баруун бүсэд 51%, Улаанбаатарт 27% байна.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед олон мянган хүн эрхэлсэн ажилгүй болж, хүмүүс амь зуухын тулд бүхий л боломжийг хайж ирсэний дотор нийгмийн мал хувьчлагдаж мал сүрэг хувь хүмүүсийн гар дээр очсоноор шинэ малчдын тоо нэмэгдсэн юм. 100000 гаруй хүн шинээр мал аж ахуй эрхэлж, мал сүргийн тоо нэмэгдсэн боловч бэлчээр ашиглах уламжлал орхигдож, шинэ малчдын дадлага, ур чадвар, малтай харьцах, нутаг, бэлчээр сонгон ашиглах, хамгаалах арга ажиллагаа дутагдсанаас шалтгаалан бэлчээр хүчтэй доройтолд орох, сүйрэх сөрөг үр дагавар ажиглагдаж эхлэв. Ядуурлын эрсдлийг бууруулах стратеги нь ашигт малтмал албан бусаар олборлох, сайн боловсрол, ажлын байр олохын тулд төв суурин газрууд руу шилжин суурьших, хөдөө орон нутаг эзгүйрэх, Өмнөд Солонгос болон бусад орнуудад ажиллах хүч экспортлох зэрэг сэтгэл зовоосон асуудлуудыг зохицуулахаас гадна дотоодод үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, орлогын олон янз байдал, хувилбарыг дэмжих зэргээр дотоод хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэгдэх ёстой.

### 1.2.2. Хөдөө аж ахуй

Монгол орон нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хүйтэн өвөл удаан үргэлжилж, хур тунадас бага унадаг нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ноцтой бэрхшээл учруулдаг.

Нэгдүгээр сар нь жилийн хамгийн хүйтэн сар бөгөөд агаарын дундаж температур -20 - - 27 °C-ийн хооронд хэлбэлздэг. 11-р сараас 3-р сар хүртэл хугацаанд цасан бүрхүүл 10-20 см-ийн зузаантай тогтоно.

Ерөнхийдөө, ургалтын хугацаа богино, хатуу хүйтэн өвөлтэй учраас зөвхөн зусах таримлуудын эрт юмуу дунд болцтой сортуудыг (улаан буудай, арвай, төмс болон бусад) л тариалах боломжтой юм. Жилийн аль ч хугацаанд хяруу унах магадлалтай, хавар орой юмуу намар эрт ойр ойрхон хяруу унах нь зусах таримлын ялангуяа төмсний чанар, ургацад сөргөөр нөлөөлдөг. Жилийн дундаж тунадас тариалангийн гол бүсэд 280-360 мм байдаг бол говийн бүсэд 100мм хүрэхгүй тунадас унадаг.

Монгол улсын нийт ажиллах хүчний 40,2% нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг бөгөөд ДНБ-ий үйлдвэрлэлд 20.5% (2005 оны байдлаар)-ийн хувь нэмэр оруулсаны 80%-ийг мал ахуйн салбарынхан оруулсан байна. Энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж тун доогуур бөгөөд хөдөө орон нутагт газар тариалангийн үйлдвэрлэл зогсож, тэнд ажиллаж байсан хүмүүсийн дийлэнх нь үндсэн ажлаасаа хөндийрсөнөөс, ажилгүй иргэдийн тоо өндөр байгааг харуулж байна. Сүүлийн 10 жилд том хэмжээний механикжсан улсын сангийн аж ахуйнуудын үйл ажиллагаа зогсож, ханган нийлүүлэлтийн систем задарсан нь газар тариалангийн салбарыг маш их доройтуулж, эмзэг болгосон юм.

### 1.2.3. Байгаль орчны асуудлууд

Монгол орны байгаль орчин нь эх газрын уур амьсгал, эмзэг экосистемээр тодорхойлогддог. Уур амьсгалын өөрчлөлт (агаарын температур нэмэгдэх, хур тунадасны хэмжээ багасах), байгалийн нөөц (ялангуяа ус, бэлчээр)-ийн хяналтгүй хэрэглээ зэрэг нь байгаль орчны асуудлыг улам хурцатгаж байна. Газрын доройтол, биологийн төрөл зүйлийн цөөрөлт, усталт, цөлжилт зэрэг нь ноцтой аюул учруулж байгаа бөгөөд хууль эрхзүйн болон нийгмийн

түвшинд бэлчээрийн болон усны зохистой менежментийг нэн даруй төлөвлөх, нэвтрүүлэх шаардлага байгааг харуулж байна. Хөдөө орон нутаг ядуурал нэмэгдсэнтэй холбоотойгоор байгалийн баялаг руу дайрах нь ихэсч ан агнах, хууль бусаар мод бэлтгэх, ховор эмийн ургамлуудыг түүх, машины мөр/зам эмх замбараагүй гаргах, хяналтгүй олборлолт явуулах, бэлчээрийг хэт талхлах зэргээр байгалийн нөөцийн хомсдол үүсгэж байна.

Монгол улсын сайн сайхан аж байдал нь байгалийн баялаг (хөдөө аж ахуй, ашигт малтмалын олборлолт, аялал жуулчлал)-аас шууд хамааралтай учраас байгалийн нөөцийн зохистой менежментийг бий болгох, хурдацтай явагдаж буй хотжилт, төвлөрлийн хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг экологийн асуудлуудыг оновчтой шийдвэрлэх нь тогтвортой хөгжлийн үндсэн асуудал болно.

#### **1.2.4. Зохицуулалтын цар хүрээ**

##### **Засгийн газрын бодлого**

Монгол улсын гол бодлогын бичиг баримтууд нь хөдөө аж ахуйн салбарт ядуурлыг бууруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилготой Мянганы хөгжлийн зорилт (МХЗ), Үндэсний хөгжлийн стратеги (ҮХС), Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги (ЭЗӨДЯБС) эдгээрийн дотроос ялангуяа Ногоон хувьсгал хөтөлбөр (НХХ) нь тариалангийн салбарт чиглэсэн баримт бичиг юм.

ЭЗӨДЯБС-ийн хүрээн дэх нэг зорилт нь 2006 онд газар тариалангийн үйлдвэрлэлийн салбарын өсөлтийг 4%-аар нэмэгдүүлэх стратеги юм (Монгол улсын Засгийн газар, 2003).

МХЗ#1-т хүрэх боломжийг судалсан анхны дүн шинжилгээ, Монгол улсын Засгийн газрын үнэлгээгээр доноруудын хүчин чармайлт, дэмжлэггүйгээр товлосон хугацаандаа (2015) зорилтоо биелүүлэх боломжгүй гэж үзсэн байдаг. 2004-2008 оны шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөө аж ахуйг хөгжүүлэх товлосон зорилт нь тариалангийн технологийг боловсронгуй болгох, хүрээлэн буй орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх эх суурийг тавин, дотоодын төмсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний төмсний эрэлт хэрэгцээний 90%-ийг хангах (Монгол улсын Засгийн газар 2004) явдал гэж тодорхойлсон байна.

Монгол улсын Засгийн газар нь Ногоон хувьсгал хөтөлбөрийн хүрээнд 1997 оноос бага хэмжээний хүнсний ногоо тариалагчдыг дэмжих үйл ажиллагааг явуулж, эхний үе шат нь 2005 онд дууссан.

Энэхүү хөтөлбөр хэрэгжих хугацаанд төмс, хүнсний ногоо тариалдаг айл өрхийн тоо хурдацтай нэмэгдэж, 2004 онд 38000-д хүрсэн ба хүнсний ногооны нийт талбайн 60%-ийг 1га-аас бага талбай бүхий үйлдвэрлэгчид эзэлж байгаа юм.

Ногоон хувьсгал хөтөлбөрийн хоёрдугаар үе шат 2006 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 5 жилийн хугацаанд үргэлжлэх юм.

##### **ШХА-ийн бодлого**

##### **ШХА-ийн Монгол дахь хөтөлбөрүүд**

ШХА-ийн Монгол дахь үйл ажиллагаа нь Монгол улсын хөтөлбөрийн стратегитай нягт уялдаатай.

Энэхүү стратеги нь Монгол улсын хөгжлийн зорилтууд, Эдийн засгийн өсөлтийг дэмжих ба ядуурлыг бууруулах стратеги, тэдгээрийн зохицуулалтын дагуу Монгол улсын баруун бүсийн малчид, хөдөөгийн

ядуучуудыг голлон анхаарч, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бий болгосноор хөдөөг хөгжүүлэх чиглэл барьж ажиллаж байна.

Швейцарын хөгжлийн стратеги нь ядуурлыг бууруулах (МХЗ #1), байгалийн нөөцийн тогтвортой менежмент (МХЗ #7), хүний эрх, ардчиллыг дээдэлсэн удирдлагыг бэхжүүлэх (МХЗ #9)-эд хувь нэмрээ оруулах зорилготой.

ШХА-ийн үйл ажиллагаа нь нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдэж, аливаа зөрчил мөргөлдөөнөөс сэргийлж, сайн засаглал, эдийн засгийн хөгжил дэвшлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах зэрэг нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд голлон анхаардаг. SDC нь хамтран ажиллагч орнуудынхаа хүчин чадлыг бэхжүүлж, цаашид бие даан тогтвортой ажиллах чадварыг нь дээшлүүлэхийг гол зорилгоо болгодог.

Монгол улсын Засгийн газар нь зохицуулах үүрэг амлалтаа биелүүлэх замаар тусламжийн үр ашгийг сайжруулах боломжийг хангаж байна.

### **1.3. Монголын төмсний салбарын үйл ажиллагаа**


Монгол улсад улаан буудайн дараа ордог хоёр дахь том хүнсний таримал бол төмс юм. Улсын хэмжээнд жил бүр 100000-120000 тн хүнсний хэрэглээний төмс зах зээлд борлуулагддагийн дийлэнх нь Улаанбаатарт борлуулагддаг байна.

2003 онд Улаанбаатар хотод нэг хүний төмсний дундаж хэрэглээ 82кг-д хүрсэн (МХШТФХ, 2004) боловч хөдөөгийн малчдын нэг хүнд ноогдох төмсний хэрэглээ 10кг-аас бага байна. Монгол төмс нь Хятад, Оросоос импортоор орж ирсэн төмстэй зэрэгцэн борлуулагдаж байгаа бөгөөд хэрэглэгчид импортын төмснөөс 40%-аар илүү үнээр нутгийн, экологийн цэвэр төмсийг худалдан авахыг илүүд үзэж байна (Монгол улсын Засгийн газар, 2000).

Монгол төмс амт чанар, махлаг эдийн өнгөөрөө хэрэглэгчдийн таашаалд нийцэхээс гадна химийн бодисоор бага бохирдсон эрүүл бүтээгдэхүүн гэдгээрээ худалдан авагчдыг өөртөө татаж байна. Тариалах талбайн хэмжээ 2003 онд 8421га байснаа 2006 онд 10600 болж, үйлдэрлэлийн хэмжээ 2003 онд 78673тн байснаа 2006 онд 109000тн болж тус тус өссөн (XXX зураг)-өөс гадна, нэгжийн ургац 2003 онд 9.3тн/га байсан бол 2006 онд 10.3тн/га болсон байна.

Гэсэн хэдий ч төмсний нийт үйлдвэрлэл, ургацын дундаж хэмжээ 1980-1990 оны үеийнхээс бага байгаа юм. Доорх зургаас харахад ургацын муруй 1990 оноос хойш ерөнхийдөө буурах хандлагатай байсан бол сүүлийн жилүүдэд өгсөж иржээ. Ургацын хэлбэлзэл өндөр байгаа нь газар тариалангийн үйлдвэрлэл цаг агаараас шууд хамааралтай гэдгийг харуулж байна. (1999 – 2002 оны зуд, 2005 оны ган).

**Зураг 1: 1989-2006 оны хугацаан дахь Монголын төмсний үйлдвэрлэл**  
(Эх сурвалж: Улсын статистикийн эмхтгэл, ХХААЯ-ны 2006 оны статистикийн тайлан)




Одоогийн байдлаар улсын нийт хэрэгцээний 60-70% -ийг дотоодын төмсний үйлдвэрлэлээр хангаж, үлдсэн хувийг Хятадаас импортоор оруулж ирсэн төмс хангаж байна. 2004-2006 оны хугацаанд Монгол улс жил бүр 3.3-3.5 сая америк долларын үнэ бүхий 35300-37200 тн хүнсний төмсийг импортоор авсан байна. (2004-2006 оны гадаад худалдааны статистик мэдээнээс).

Төрөөс “Ногоон хувьсгал”-ыг эхлүүлсэнтэй холбоотойгоор 126000 өрх хүнсний ногоо тариалж, олон ТББ-ууд ядуурлыг бууруулах хөтөлбөрөөрөө дамжуулан төмс, хүнсний ногоо тариалалтыг дэмжих болсон.

Хүнсний ногооны үйлдвэрлэл (төмсийг оролцуулан) нь өрхийн түвшинд хүнсний аюулгүй байдлыг хангах гол үндэс болж байна. Гэсэн хэдий ч, эдгээр жижиг үйлдвэрлэгчдийн зах зээлд оруулах хувь нэмэр нь ялихгүй бага юм. Зураг 2-т үзүүлснээр төмс тариалагчдын ихэнх нь 0.1га-аас бага хэмжээний талбайд тариалдаг бөгөөд улсын хэмжээний төмс үйлдвэрлэлийн 1/3-ийг 5.4га-аас том хэмжээний талбайд төмс тариалагчид хангасан байна. Жижиг үйлдвэрлэгчид нь дунджаар 0.01га талбайд ихэвчлэн өөрсдийн хэрэгцээндээ зориулан хашаандаа төмс тариалж, боломжийн хэмжээний ургац хураан авчээ. Дунджаар 0.3 га-д төмс тариалдаг хоёр дахь жижиг хэмжээний үйлдвэрлэгчид нь хамгийн бага ургац хураан авсан байна. Энэ нь тэдгээрийн дэмжвэл цаашид хөгжлийн боломж байгааг харуулж байгаа юм. Жижиг фермерүүд нь голдуу өмнө нь төмс тариалж байсан туршлага багатай, үр, технологи, хадгалалтын талаар мэдлэг хомс, зах зээлийн туршлага, санхүүгийн чадвар муутай байдаг учраас зайлшгүй дэмжлэг хүлээж байгаа хэсэг болно.

**Зураг 2: Монголын төмсний үйлдвэрлэл– 2004<sup>1</sup>-оны тооцоо**



**Агротехнологи**

Үрийн болон хүнсний төмснийг “уринш-төмс” гэсэн хоёр талбайт, “уринш-төмс-амуу тариа” гэсэн гурван талбайт сэлгээтэйгээр ээлжлэн тариалах системд тариалж байна. Сортуудыг сонгон авахдаа вегатацийн хугацаа богинотойг илүүд үздэг ба гол төлөв нэн эрт, эрт, дунд эртийн сортуудыг тариалдаг. Тариалалтын хугацаа эрт буюу ихэвчлэн 5-р сарын дундуур, хураалтын хугацаа 8-р сарын сүүлээс 9-р сарыг дуустал байдаг. Тариалалтанд хэрэглэгддэг багаж төхөөрөмж нь голдуу хуучирсан, олдоц ховор байдаг учраас тариаланчид техник хэрэгслийг түрээслэх юмуу эсвэл гар аргаар төмсөө тариалдаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед эрдэс, органик бууцан бордоо байнга хэрэглэж байснаа 1990 оноос хойш бараг бордоо хэрэглэхээ больсон учраас сүүлийн жилүүдэд хөрсний үржил шим ихээхэн муудсан байна. Мөн сүүлийн 10 гаруй жил ургамал хамгааллын арга хэмжээ авах нь эрс багассан байна. Гэтэл өвчин, хортон шавьжийн тархалтанд үнэлгээ хийж үзэхэд ургалтын хугацаанд халдвар авсанаас ургац 30-50%-аар буурдаг болохыг тогтоожээ (ХААИС). Монголын газар тариалангийн системд пестицидийг болгоомжтой хэрэглэх бодит нөхцөл бий бөгөөд 1990 оноос өмнө хэрэглэж байсан ихэнх химийн бодисууд нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй учраас удаан хэрэглэхээс зайлсхийх нь зүйтэй.

<sup>1</sup> Ногоон хувьсгал хөтөлбөрийн тайлан, улсын статистикийн мэдээ болон ХХААЯ-ны тайлангууд, 2004 онд Улсын статистикийн газраас явуулсан тариалангийн талбайн тооллогын мэдээ зэрэг баримтуудаас түүвэрлэн авсан. Улсын статистик мэдээ нь ХХАА-н яамныхаас 227га-гаар бага гарсан. Энэ нь 0.1га-аас бага талбай бүхий үйлдвэрлэгчид зөвхөн өөрсдийн хэрэгцээний хүнсэнд ашигладаг учир улсын статистикт тусгагдаагүй.

Шинэ төрлийн пестицидийн сорилт, баталгаажуулалт, хэрэглээ байхгүй, мөн өвчин, хортон шавьжтай тэмцэх биологийн аргыг турших, нэвтрүүлэх талаар бараг ажил хийгдээгүй гэж үзэж болно.

Хуурай, хүйтэн цаг агаарын нөхцөлд химийн бодисуудын задралын явц ямар байдаг талаар дүн мэдээ байхгүй. Хог ургамалтай тэмцэх ажил бүхэлдээ механик аргаар хийгдэж байсан (ургалтын хугацаанд борнойдох, мөр хооронд сийрүүлэх зэрэг).

Усалгаагүй нөхцөлд төмсний таримал цухуйж эхэлсэний дараа хог ургамалтай механикаар аргаар тэмцэх боломжтой. Учир нь хог ургамал харьцангуй бага тархана.

Харин усалгаатай нөхцөлд хог ургамлын тархалт ихсэх учир механик аргаар тэмцэх нь үр дүн багатай. Монголын харьцангуй цэвэр хөрсийг бохирдохоос сэргийлэх, пестицид хэрэглэхээс аль болох зайлсхийх шаардлагатай. Анхны хяруу ихэвчлэн 8-р сарын сүүлээр унадаг учраас ургац хураахын өмнө навчийг зориудаар хагдраах ажил хийгддэггүй. Энэхүү практикийг хүнсний төмсөнд үргэлжлүүлэн мөрдөх бөгөөд чанартай үрийн төмсний үйлдвэрлэлд оновчтой технологи сонгон нэвтрүүлэх, тэгэхдээ аль болох биологийн аргыг түлхүү ашиглах шаардлага гарч байна.

### Төмсний хадгалалт

Монголын нөхцөлд хүнсний хэрэглээний болон үрийн төмсийг удаан хугацаагаар хадгалах шаардлага гардаг. Үрийн төмсийг 9-р сарын дундаас 5-р сарын эхэн хүртэл 220-240 хоног хадгална.

Хэрэглээний төмсийг 6-р сар хүртэл одоогийн аргын дагуу тохиромжтой нөхцөлд хадгална. Төмсний хадгалалтын зардал өртөг нэлээд өндөр юм. Учир нь урт хугацааны туршид хадгалалтын менежмент хийх, температур, чийгийн горимыг тохируулах (хөргөх, халаах, салхилуулах)-д тодорхой хугацаа, зардал, цахилгаан ордог. Үүнээс гадна хэмжээнээсээ хамаарч төмс нь нэлээд их зай талбай эзэлдэг тул энэ бүтээгдэхүүний зардал өртгийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болно. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед хот суурин газруудын эргэн тойронд 100000тн-ийн багтаамжтай олон зоорь барьсаны олонх нь одоо ашиглагдахгүй байгаа бөгөөд зоорины чанар, технологийг сайжруулах ялангуяа агааржуулалт, агаарын температурыг хянах зэрэг менежмент хийх хэрэгтэй байна.

Төмс хадгалах технологи, хадгалалтын өмнөх ба дараах тариалалтанд бэлтгэх арга хэмжээг зохион байгуулах мэдлэг дадлага хангалтгүй байгаагаас хадгалалтын хорогдол ихсэх, өвчлөлт нэмэгдэх үндэслэл болж байна.

Химийн бодисын хэрэглээ одоогоор маш бага, ялангуяа соёололтыг дарангуйлах бодисууд хэрэглэгдэхгүй байгаа боловч хэрэгцээ өсөх хандлагатай байна. Иймээс менежментийг сайжруулах химийн бодисын хэрэглээг байж болох хамгийн бага хэмжээнд хязгаарлах нь чухал юм.

### Хүснэгт 1: 2004-2006 онд импортлосон төмсний хэмжээ (тн)

| Хаанаас импортлосон: | 2004    |       | 2005    |       | 2006    |       |
|----------------------|---------|-------|---------|-------|---------|-------|
|                      | хүнсний | үрийн | хүнсний | үрийн | хүнсний | үрийн |
| Голланд*             |         | 25    |         |       |         |       |
| Герман*              |         | 0.65  |         |       |         |       |
| Орос                 | 0.4     |       | 15      |       |         |       |
| Хятад                | 36833.8 |       | 37250.3 | 71.9  | 35314.9 |       |

|             |                |              |                |             |                |  |
|-------------|----------------|--------------|----------------|-------------|----------------|--|
| <b>Нийт</b> | <b>36834.2</b> | <b>25.65</b> | <b>37265.3</b> | <b>71.9</b> | <b>35314.9</b> |  |
|-------------|----------------|--------------|----------------|-------------|----------------|--|

- ХХААЯ ба төслийн сорилт туршилтын журмаар импортлосон шинэ сортын үрийн төмс
- Эх сурвалж: Гадаад худалдааны статистик тоон мэдээнээс

### **Үрийн үйлдвэрлэл:**

Монгол орон нь байршлын хувьд өндөрлөг газар нутагт оршдог учраас сайн чанартай төмсний үр үйлдвэрлэхэд цаг уурын хувьд давуу талтай. Хатуу ширүүн өвлийн улиралтай учир хөрсөнд элдэв халдвар хадгалагдан үржих явдлыг хязгаарлаж, хөрсний бохирдлыг багасган, төмсний таримлаас харьцангуй бага зардлаар сайн чанартай үрийн материал үйлдвэрлэх боломжийг олгож байна. Хэрэв оновчтой арга хэмжээ авч чадвал энэхүү нөхцөл нь Монголчуудад эмгэгээс ангижирсан, физиологийн хувьд чанар сайтай төмсний үр үйлдвэрлэх өрсөлдөөний талбарыг бий болгох юм. Хэдийгээр чанартай үр үйлдвэрлэхэд таатай боловч ургалтын хугацаа богино, эрт хяруу унах өндөр эрсдэлтэйг бодолцон тарих сортуудын сонголтонд зайлшгүй анхаарах шаардлага гардаг. Нөгөө талаар Монголын цаг агаарын эрсдэл (хавар орой, намар эрт хяруу унах, ган) нь төмсний үйлдвэрлэлийг бүхэлд нь болон тариалангийн тодорхой хэсгүүдэд ургац алдахад хүргэдэг. Эдгээр цаг уурын сөрөг нөлөө нь (ургалтын хугацаа богиныг оролцуулан) үр үйлдвэрлэлийн хэмжээг хязгаарлаж, зарим жилүүдэд үрийн төмсний олдоцыг багасган, үр шинэчлэлийг төлөвлөсөн хэмжээнд явуулахад бэрхшээл учруулдаг.

## **1.4. Төслийн хүрсэн үр дүн ба 2-р үе шатны бэлтгэл ажил**

### **1.4.1. Төслийн үндэслэл**

Монголын төмсний үйлдвэрлэлийг сайжруулах Монгол улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу ШХА нь Монголын төмсний салбарт судалгаа явуулж, төмсний үрийн чанар муу, оновчтой технологи дутагдалтай байгаа нь төмсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд гол бэрхшээл учруулж байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Энэхүү судалгаан дээр үндэслэн ШХА нь үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэх, төмсний үр үйлдвэрлэлийн системийг бүтцийн хувьд өөрчлөх болон төмс үйлдвэрлэлийн гол субъектууд төрийн ба хувийн салбарын хамтын ажиллагааг дэмжих замаар төмсний үрийн хангалтын төвлөрсөн системийг өөрчлөх зорилгоор хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

### **1.4.2. Хүрсэн үр дүн**

Хөтөлбөр нь Европ, Хойд Америк, Хятад зэрэг дэлхийн бөмбөрцгийн хойд өргөрөг дэх бүс нутаг, тэдгээрийг төлөөлөх орнуудаас төмсний сортуудыг судалгаанд оруулж, Монгол орны янз бүрийн хэсгүүдэд сорилт туршилт явуулсан. Эдгээрээс хэд хэдэн сорт нь Монгол орны нөхцөлд тохиромжтой нь илэрсэн бөгөөд дараах 3 сорт нь албан ёсоор ирээдүйтэй сортоор батлагдаад байна.

2004 онд Витара ((Германаас  
2006 онд Импала (Голландаас)  
2007 онд Санте (Голландаас

Хөтөлбөр нь эхний шатанд тухайн улс орнуудаас импортлон авчирсан элит үр, дараагийн шатанд түүнийг цэврээр үржүүлж Монголд үйлдвэрлэсэн өвчлөлгүй үрийн материал дээр үндэслэн үр үржүүлгийн ажлыг хийж байна. Хөтөлбөр нь 2006 онд анх удаа албан бус үр үржүүлэгчдийг Импала, Витара сортын үр (импортоор оруулж ирсэн элит үрийн үржүүлэг дээр үндэслэн)-ээр хангасан. Эдгээр хоёр шинэ сорт нь Монголын нөхцөлд ирээдүйтэй сортоор шалгарсан бөгөөд фермерүүдийн өмнө тариалж байсан сортуудаас хоёр дахин их ургац өгсөн. 2006 онд улсын хэмжээнд 26 үр үржүүлэгч Импалагаас 20тн/га-ийн дундаж ургац авсан бөгөөд нийтдээ 93тн төмс үйлдвэрлэсэний нэлээд хувь нь 2007 онд үрийн зориулалтаар тариалагдсан. Витара, Санте сортын үрийн үйлдвэрлэл Импала-гийнхаас анхдагч үр бага хэмжээтэй байсан учраас ялимгүй хоцорч яваа.

Эдгээр шинэ сортууд нь зөвхөн ургацын хэмжээгээрээ өндөр үзүүлэлттэй төдийгүй мөн зах зээл, хэрэглэгчдээс өндөр үнэлгээ аваад байгаа юм.

Улаанбаатар хотын зарим супермаркетуудын сүлжээгээр бусад төмс 450 төгрөгийн үнэтэй байхад Импала сортын төмс 600 төгрөгөөр борлуулагдаж байна.

Үүнээс харахад эдгээр шинэ сортуудын хэрэгцээ шаардлага маш өндөр байгаа юм.

Хүснэгт 2-д Монголын үр үйлдвэрлэлийн схемийг үзүүлээ.

## Хүснэгт 2: Үр үйлдвэрлэлийн схем ба үрийн ангилал

| Тариалсан үрийн ангилал         | Үржүүлсэн газар                                       | Хурааж авсан үрийн ангилал                          | Үржүүлэгчид   |
|---------------------------------|---|---|---|
| Өвчлөлгүй үрийн сан in-vitro    | Лаборатори  | Өвчлөлгүй in-vitro ургамал                          | Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд (УГТСЭШХ, УХЭШХ )                                   |
| Өвчлөлгүй in-vitro ургамаланцар | Хүлэмж  | Өвчлөлгүй бэсрэг-булцуу                             |   |
| Өвчлөлгүй бэсрэг-булцуу         | Талбайд ( 1-р үржүүлэг)                               | Супер–Супер-Элит                                    | <b>Албан</b> үр үржүүлэгчид (Улсын 4 хүрээлэн/салбарууд, 4 хувиараа үр үржүүлэгчид) |
| Супер-Супер-Элит                | Талбайд (2-р үржүүлэг)                                | Супер-Элит  |   |
| Супер-Элит                      | Талбайд (3-р үржүүлэг)                                | Элит  |   |
| Элит                            | Талбайд (4-р үржүүлэг)                                | Баталгаат үр  | <b>Албан бус</b> үр үржүүлэгчид   |
| Баталгаат үр                    | Талбайд (5-р үржүүлэг)                                | Баталгаат үр  |   |
| Баталгаат үр                    | Худалдааны зорилгоор үйлдвэрлэх 2-р репродукцаас дээш | Хүнсний төмс юмуу фермерүүдийн хадгалсан үрийн төмс | Бүх тариалагчид   |

Хөтөлбөрөөс 2 эрдэм шинжилгээний хүрээлэнд өвчлөлгүй үр үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Эдгээр бэсрэг булцууны гарц сүүлийн

гурван жилийн хугацаанд 50000 (Хөтөлбөр эхлэхээс өмнөх тооцоогоор)-аас 130000 болж нэмэгдсэн (Хүснэгт 3).

### Хүснэгт 3: Өвчлөлгүй үрийн (бэсрэг булцууны) үйлдвэрлэл

| Он   | УГТСЭШХ | УХЭШХ | Нийт          |
|------|---------|-------|---------------|
| 2004 | 55529   | 15000 | <b>72533</b>  |
| 2005 | 63397   | 44300 | <b>109702</b> |
| 2006 | 65660   | 63100 | <b>130766</b> |

Хөтөлбөр нь энэхүү бэсрэг булцууны үйлдвэрлэлийг лизензтэй 4 албан үр үржүүлэгчтэй холбон талбайд шилжүүлэн үржүүлүүлж байна. 2006 онд эдгээр 4 албан үржүүлэгчид болон бусад улсын эрдэм шинжилгээний хүрээлэн, салбаруудад нийтдээ 324тн үр үйлдвэрлэсэн. (Хүснэгт 4). Эдгээр үрийн тодорхой хэсгийг 'Хонгор' (Казакстаны эрлийз материалаас селекцээр гарган авсан), 'Приекульский ранний' (Оросын сорт), 'Астила' (Зүүн Германаас гаралтай сорт) зэрэг Монголд өмнө нутагшсан сортуудын үр эзэлж байгаа юм.

### Хүснэгт 4:

#### Хөтөлбөрийн албан үр үржүүлэгчдийн үр үйлдвэрлэлийн хэмжээ

| Он   | 2004  | 2005  | 2006  |
|--|-------|-------|-------|
| Албан үр үржүүлэгчдийн үр үйлдвэрлэлийн нийт хэмжээ (тн) | 252.6 | 288.0 | 324.0 |

Хэрэв 2005 онд гэнэтийн хуурайшилт тохиолдоогүй бол өнөөдөр үр үйлдвэрлэлийн хэмжээ өндөр байх бололцоотой байсан. Өнгөрсөн жил УГТСЭШХ ургац алдаж, анхдагч үрийн аж ахуйн бүх талбайдаа төлөвлөсөн хэмжээний ургац авч чадсангүй.

Амьдралаас харахад үр үржүүлгийг төвлөрлөөс гаргах, анхдагч үрийн аж ахуйн талбаруудыг усалгаанд шилжүүлэх замаар үрийн эх материал болон дээд үржүүлгийн үе шатуудыг цаг агаарын эрсдлээс хамгаалах явдал үржүүлгийн үе шатуудыг хэвийн , төлөвлөгөөний дагуу явуулах үндсэн нөхцөл болж байна.

2005 онд ган болсноос шалтгаалан Хөтөлбөрийн хамгийн чухал үржүүлгийн талбайн нэгийг нөхөн сэргээх, үрийн материалаар хангах шаардлага тулгарсан.

Хөтөлбөр нь 2007 онд 21 аймгийн 90 гаруй туршлагатай албан бус үр үржүүлэгчдийг сонгон авч, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Эдгээр үр үржүүлэгчид нь Хөтөлбөрөөс хоёр тонн элит үрийг зээлээр аваад ургацаа хурааж авсаны дараа 4 тонн болгон буцааж тушаах ёстой. Тэд ихэвчлэн эхний жилдээ нийт үрийн нөөцөө шинэчлэх, 2 дахь жилдээ болж өгвөл ихэнх талбайдаа үрээ шинэчлэх зорилгоор шинэ сортуудын үр үржүүлж байна. (дунджаар 2-3га).

### Хүснэгт 5: Хөтөлбөрөөс сонгосон албан бус үр үржүүлэгчдийн өсөлт

| Он | Албан бус үр үржүүлэгчийн | Аймгийн тоо | Сумын тоо | Хөтөлбөрөөс хангасан нийт |
|----|---------------------------|-------------|-----------|---------------------------|
|----|---------------------------|-------------|-----------|---------------------------|

|      | тоо |    |    | үрийн хэмжээ<br>(тн) |
|------|-----|----|----|----------------------|
| 2004 | 13  | 5  | 12 | 60.0                 |
| 2005 | 9   | 5  | 9  | 13.5                 |
| 2006 | 36  | 17 | 32 | 43.0                 |
| 2007 | 90  | 21 | 72 | 86.0                 |

Хөтөлбөр нь албан ба албан бус үр үржүүлэгчдийг усалгааны тоног төхөөрөмж худалдан авах, зоорины нөхцлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгодог.

Мөн улсын хэмжээнд тариалагчдад хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх систем байхгүй учраас Хөтөлбөрийн зүгээс үр болон бусад төрлийн хөнгөлөлт/дэмжлэг үзүүлэх нь зөв.

Хөтөлбөр нь үрийн төвлөрсөн бус хангалтын систем бий болгох ажлыг маш амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд шинэ сортуудыг богино хугацаанд туршиж, нэвтрүүлэн, бүх оролцогч талууд (эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, албан ба албан бус үр үржүүлэгчид)-ыг холбон ажилласан.

Үр үйлдвэрлэлийн системд тодорхой завсрын үе шат байдаг бөгөөд үүнийг мэргэжлийн хэлээр анхдагч үрийн аж ахуй гэдэг: Төмсийг лабораторийн нөхцөлд үржүүлсний дараа эхний элит үрийг худалдаанд гаргах хүртэл доод тал нь 4 жилийн хугацаа ордог. Энэ хугацаанд нэг үе шатнаас нөгөө үе шатанд төмсний хэмжээ ихсэхийн хирээр үйлдвэрлэлийн өртөг зэрэгцэн нэмэгддэг учраас энэ завсрын үе шатанд орлого олох боломж байдаггүй.

Үүний адил, албан бус үр үржүүлэгчдэд шууд их хэмжээгээр үр өгөх боломжгүй учир бага хэмжээний элит үр хүлээж аваад өөрийн үрийн нөөцөө бүрэн шинэчлээд бусдад худалдах хүртэл 2 жилийн хугацаа шаардагдана.

Хөтөлбөр нь энэхүү санхүүгийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэсэн. Зарим оролцогч талууд нь санхүүгийн чадавхи муутай, ийм шинэ төрлийн аз туршсан алхам хийж, эрсдэлтэй тулгарахад бэлэн биш байдаг. Одоогийн байдлаар хөтөлбөр нь үржүүлгийн сүлжээгээр "өөрийн" тодорхой хэмжээний үрийн нөөцтэй болоод байгаа бөгөөд энэ нь яваандаа үйлдвэрлэгчид авсан зээлээ эргэн төлөх үед Хөтөлбөрт буцаж ирэх юм.

#### 1.4.3. 2-р үе шатны үндэслэл

Хоёрдугаар үе шатны гол үндэслэл нь нэгдүгээр үе шатанд амжилттай эхлүүлсэн үржүүлгийн сүлжээг үргэлжлүүлэх явдал юм. Үр үржүүлгийн сүлжээг цаашид нэлээд хэдэн жил дэмжих хэрэгтэй байна: Нэг талаар, үр нь үйлдвэрлэгч ба хөтөлбөрийн аль алины хувьд орлого үүсч эхлэх үр үржүүлгийн сүлжээний төгсгөлд хүрээгүй байгаа бөгөөд Хөтөлбөрт эрт хамрагдсан үр үржүүлэгчид шинэ сортын үр үйлдвэрлэж, борлуулж эхэлсэнийг хараад дараагийн 2 жилд шинээр албан бус үр үржүүлэгчид системд нэмэгдэж орох хандлагатай байна.

Нөгөө талаар сүлжээг бүх оролцогч талуудад үр ашигтай байхаар оновчтой болгохын тулд Хөтөлбөрийн зүгээс лабораторид хөрөнгө оруулалт хийх, хүлэмжийн болон талбайн усалгааны тоног төхөөрөмж, үрээр хангах, чанарын хяналтыг бэхжүүлэх, сорт сорилт, үнэлгээг эрчимжүүлэх зэрэг ажлуудыг хийх нь үрийн хангалтын системийг тогтвортой болгоход чухал ач холбогдолтой.

Хөтөлбөрийн эхний үе шатанд хүрсэн ололт амжилтаас ашиг гаргахын тулд үрийн хангалтын системийг оновчтой болгох нь чухал. Энэ нь илүү үр өгөөжтэй, эрүүл, зах зээлийн харилцаан дээр үндэслэсэн байх ёстой.

Мөн систем дэх оролцогч талуудын зах зээлийн харилцан холбоог дэмжихийн тулд өртөгийн үнэлгээг хийх, шинэчлэх шаардлагатай.

Үр, сортын ажлыг сайжруулахын тулд дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай:

Шинэ сортуудын үрийг жижиг фермерүүдэд хүргэх; фермерүүдийн онцлог байдал, хүндрэлтэй асуудлыг таньж ойлгосноор тус бүрт нь тохирсон дэмжлэг үзүүлэх, хүчин чадал багатай жижиг фермерүүдийн үйлдвэрлэлийг сайжруулах арга нэвтрүүлэх, хэрэглээ, хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх, хангалтын сүлжээг сайжруулах стратеги боловсруулахгүй бол яваандаа хэт их хэмжээний төмс үйлдвэрлэгдэх эрсдэл гарч болох юм.

#### 1.4.4. 2-р үе шатны бэлтгэл шат

2007 оны 2-р сард хөтөлбөрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дунд шатны үнэлгээ хийгдсэн. ШХА нь 4-р сард төлөвлөлтийн шинэ үе шатны мөрийн хөтөлбөрийг боловсруулж тодорхойлж гаргасан байна.

- Үе шатны үргэлжлэх хугацаа: 4 жил (2008 оны 1-р сараас 2011 оны 12-р сар дуустал)
- Төслийн хэрэгжүүлэгч байгууллага (Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, ТББ)
- Төслийн Монгол улсын Засгийн газрын бодлого, 2007-2012 оны Швейцарийн хөгжлийн стратегитай нийцэж, тохирч буй эсэх
- 2007 оны 5-р сард олон улсын зөвлөх 2-р үе шатны төслийн санал боловсруулах ажилд тусалсан. Бүх оролцогч талуудтай өргөн хүрээнд хэлэлцсэний үр дүнд төслийн шинэ үе шатыг тодорхойлоод байна. 5-р сарын 4-ний төлөвлөлтийн семинарын 1-р хэсэгт оролцогч талууд өөрсдийн санал бодол, хүлээгдэж буй үр дүн, үйл ажиллагааны талаар хэлэлцсэн. Энэхүү төлөвлөлтийн шатны семинарын 2 дахь хэсэгт Хөтөлбөрийн Удирдлагын Нэгж, ШХА-ийн ажилтнууд, сонгогдсон хамтран ажиллагсад оролцож, төслийн саналд Монголын болон ШХА-ийн бодлого, стратегийн уялдаа холбоог тусгах, дунд шатны үнэлгээний зөвлөмж, хэрэгжих боломжийн талаар нарийвчлан хэлэлцсэн байна.

Энэхүү семинарын явцад үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулсан.

Төслийн саналын анхны төсөл саналыг 2007 оны 5-6-р сард Зохицуулах хорооны гишүүдтэй өргөн хүрээнд зөвлөлдсөний дүнд гишүүдийн саналыг тусган дахин боловсруулсан байна.

## 2. "Монгол төмс" төслийн санал-2-р үе шат

### 2.1. Зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн

Төслийн 2-р үе шатны гол зорилго нь Монголын төмсний салбарын бүтээмжийг нэмэгдүүлснээр хүнсний аюулгүй байдал, хүнсний тэжээллэг хангамжийг сайжруулан, орлогыг нэмэгдүүлэх явдал юм.

#### Хүнсний аюулгүй байдал:

Үндэсний хэмжээнд импортоос хамаарал багатай болж, өрхийн түвшинд хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг олшруулах эх үүсвэрийг нэмэгдүүлэх

**Тэжээллэг чанар:** Төмс нь нэг талаас хүнсний ногоо бөгөөд нөгөө талаас хүн амын ядуу хэсгийн хүнсний бүтцэд гол үүрэг гүйцэтгэдэг хүнсний үндсэн бүтээгдэхүүн болно. Түүнчлэн хүн амын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, хүнсний эрүүл чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой

**Орлого:** Үйлдвэрлэгчдийн (жигжиг ба том) орлогыг нэмэгдүүлэх асуудал бөгөөд зөвхөн хэрэгцээ өсч байгаа үед тогтвортой байна.

**Салбарын бүтээмж:** Хангалтын сүлжээ (маркетингийн ба боловсруулалтын)

#### 2-р үе шатны төгсгөл үеийн төслийн зорилт

Үр ашигтай, тогтвортой, төвлөрсөн бус системээр ургац арвинтай шилдэг сортуудын сайн чанарын үр үйлдвэрлэснээр төмс үйлдвэрлэгчдийн ургац, ашиг орлого нь нэмэгдэнэ

Төслөөс хүлээгдэх үр дүн:

1. Орон нутгийн нөхцөлд дасан зохицсон төмсний сортуудын өндөр, тогтвортой чанартай үрийг үйлдвэрлэж, Монгол орны төмс тариалагчдад хуваарилан тараана

2. Оролцоонд тулгуурласан хөгжлийг бий болгож, оновчтой үйлдвэрлэлийн аргыг түгээн дэлгэрүүлэх замаар төмс үйлдвэрлэгчдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чадавхийг бэхжүүлнэ.

3. Төмсний хангалтын сүлжээг сайжруулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх хувилбарыг сонгон хөгжүүлэх

4. Гол оролцогч талууд (үйлдвэрлэгчээс хэрэглэгчид хүртэл)-ын үр ашигтай харилцан ажиллагаанд дөхөм болох төслийн хамрах хүрээ, бодлогыг тодорхойлохын тулд хамтын ажиллагаа, хүчин чадлаа бэхжүүлнэ

### 2.2. Ойлголтын хүрээ ба хөндлөнгийн оролцооны стратеги

Төслийн хөндлөнгөөс оролцох стратеги нь үрийн үйлдвэрлэл, шинэ сортуудыг илрүүлэн үржүүлэх чиглэлээр 1-р үе шатны ололт амжилтаа бататгах асуудал юм.

Өрхийн түвшинд ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулахын тулд жилд зарим нь дөнгөж нэг шуудай ургац хураан авдаг жижгэвтэр, жижиг үйлдвэрлэгчдэд илүү анхаарал хандуулж ажиллана. Эдгээр жижиг фермерүүд үйлдвэрлэсэн үрээ хэрхэн үр ашигтай ашиглах тал дээр төслөөс судалгаа шинжилгээ явуулах нь зүйтэй.


Ялгаатай зорилтот бүлгүүдэд харилцан адилгүй стратегиуд (тухайлбал, үрийг хадгалах боломжтой ба боломжгүйгээс хамаарч) тавигдах ба жижиг тариаланчдын талаар мэдээлэл хомс байдаг учраас тэдгээрийн стратеги төмс тариалах хүчин чадал, хязгаарлах хүчин зүйлүүдийг сайтар судлах нь чухал ач холбогдолтой.

Төслийн одоогийн оролцогч талууд нь ийм жижиг үйлдвэрлэгчдийн талаар нарийн мэдээлэлгүй байдаг учраас эдгээр үйлдвэрлэгчидтэй ойр байдаг шинэ түнш (ТББ г.м)-үүдтэй орон нутгийн түвшинд хамтарч ажиллана. Оролцооны аргад түшиглэн үр үржүүлүүлэх чиглэлээр жижиг үйлдвэрлэгчидтэй хамтарч ажиллах явцад үр, сортноос гадна тэдэнд тохиолдож буй бэрхшээлүүдийг олж илрүүлнэ. Үр ашигтай бөгөөд фермерүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль орчинд ээлтэй, нийгэмд нийцтэй үйлдвэрлэлийн аргуудыг таньж тодорхойлох бөгөөд гэхдээ шинэ арга нь бодит хүчин чадлаас хэтэрсэн байх тохиолдолд бүх түвшинд татаас өгөх боломжгүй учраас тэдэнд дэмжлэг үзүүлэн оновчтой хэлбэрийг сонгож ажиллана.

Төсөл нь төмсний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор ялгаатай түвшинд борлуулалтын сүлжээг бий болгох, дэмжих үйл ажиллагаа явуулна.

Мөн өөрсдөө төмс тариалдаггүй хөдөөгийн малчид, бусад бүлгийнхнийг хангалтын сүлжээнд хамруулж, хот суурин газрын эдийн засгийн янз бүрийн давхаргад хамрагдах хэрэглэгчдийн шинэ төмсний зах зээлийн тогтолцоог илүү үр өгөөжтэй болгох, онцлог хэрэглээтэй, боловсруулсан, шинэлэг бүтээгдэхүүнийг дэмжихэд анхаарна.

Нэмж хэлэхэд, борлуулалтын сүлжээнд оролцогч талуудыг шинээр татан оролцуулж ажиллуулахыг эрмэлзэнэ.




Төслийн хөндлөнгөөс оролцох стратеги нь 4 үндсэн зүйл дээр үндэслэнэ. Үүнд:

- 1.Төслийн анхаарал хандуулан ажиллаж байгаа үрийн үйлдвэрлэл, шинэ сортуудын нэвтрүүлэх ажил нь төрөл бүрийн түншүүдийн оролцоотойгоор хийгдэж, улс орныг нийтэд нь хамаарна.
- 2.Жижиг фермерүүдийн хамт (үр үйлдвэрлэгчид биш) үйлдвэрлэсэн үрийг хамгийн үр ашигтайгаар хэрэглэх, ашиглах, ашиглалтын аргыг сурах эзэмших ажлыг зөвхөн сонгож авсан сумуудад хагас оролцоотой, төвлөрсөн бус түншүүдэд түшиглэн явуулна
- 3.Төмсний үйлдвэрлэлд илүү үр дүнтэй, ээлтэй үйлдвэрлэлийн аргыг нэвтрүүлэхдээ цөөн суманд жижиг фермерүүдтэй ойр ажилладаг төвлөрсөн бус түншүүдэд түлхүү чиглүүлнэ; Төсөл нь байгаль, цаг уурын тодорхой нөхцөлд, тодорхой сортын үр үржүүлэх, үйлдвэрлэл явуулах чиглэлийг дэмжинэ
- 4.Түншүүдийн оролцоотой хамтран борлуулалтын сүлжээг сайжруулна; ингэхдээ цөөн тооны сонгогдсон сүлжээг хамруулна
- 5.Бодлогын түвшний үйл ажиллагааны стратеги, төмсний үр ашигтай үйлдвэрлэлийг дэмжих бодлого, төслийн хамрах хүрээг тодорхойлон нарийсган төрөлжүүлэх замаар тодорхой үр дүнд хүрэхэд чиглэгдэнэ

### 2.3. Үйл ажиллагааны логик цар хүрээ

Төслийн 2-р үе шатны үйл ажиллагааны логик цар хүрээг Хүснэгт 6-д үзүүлэв.

Зураг 4: Төслийн 1 ба 2-р үе шатанд Монголын төмсний салбарт оролцох оролцооны харьцуулсан зураг



### Хүснэгт 6: “Монгол төмс” төслийн үйл ажиллагааны логик цар хүрээ-Төслийн 2-р үе шат

| Зорилтын систем  | Үзүүлэлт   | Нотолгоо   | Чухал таамаглал   |
|--|--|--|---|
| <p><b>Төслийн зорилго:</b><br/>Монголын төмсний салбарын бүтээмжийг дээшлүүлснээр хүн амын хүнсний аюулгүй байдал, хүнсний тэжээлийн хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх</p>   | <p>2011 он гэхэд төмсний үйлдвэрлэл 50%-аар нэмэгдэнэ. (NDS)<br/>2011 онд ургацын хэмжээ 12 тн/га-д хүрнэ<br/>Үндэсний үйлдвэрлэл нь төмсний нийт хэрэглээний 80%-ийг хангана</p>  | <p>Улсын статистик мэдээ</p>   | <p>Хүрэлцээтэй байдал, сайн чанар нь хэрэглээг нэмэгдүүлдэг</p> |
| <p><b>Төслийн зорилт:</b><br/>Өндөр ургац, чанар сайтай сортуудын тогтвортой, төвлөрсөн бус, чанартай үрийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бусад төрлийн үйлдвэрлэл, боловсруулалт, дахин боловсруулалтыг сайжруулснаар төмс үйлдвэрлэгчдийн ургац, ашиг орлогыг нэмэгдүүлэх</p> | <p>Төсөлтэй шууд ба шууд бусаар хамтран ажиллаж байгаа үйлдвэрлэгчдийн усалгаагүй төмсний ургац 30%-аар нэмэгдэнэ.</p> <p>Технологийн үр ашигтай байдалд бүрэн дүүрэн, үнэн зөв үнэлгээ хийнэ</p> <p>Ургацын нэмэгдлийн олон хүчин зүйлүүдийг нийлбэр цогцоор нь авч үзэх чиглэлд өөрчлөлт гарна<br/>Үр, сорт, усалгаа, бусад арга хэмжээнүүдийг цогцоор нь авч хэрэгжүүлэхэд олон нийтийн анхаарлыг хандуулна</p> | <p>Төслийн 2011 оны жилийн тайлан (нөлөөллийн мониторингийн хэсэг)</p> |   |

|   |  |  |   |
|---|--|--|---|
| <p><b>Үр дүн 1:</b><br/>Монгол орны нөхцөлд дасан зохицсон сортуудыг өндөр, тогтвортой чанартай үрийг үйлдвэрлэж, төмс тариалагчдад хуваарилан тараана</p>  | <p>2012 он гэхэд бүх үрийн 50%-ийг шинэчилнэ</p> <p>2011 он гэхэд төмсний тариалангийн нийт талбайн 30%-д шинэ сортуудыг тариална</p>  | <p>Аймгийн статистик мэдээ</p> <p>Улсын хяналтын тайлан</p>  | <p>Төмсний үнэ эрс унахгүй (30%)</p> <p>Байгалийн гамшиг дунджаас илүү олон тохиолдохгүй</p> <p>Засгийн газрын бодлого, бүтэц нь энгийн, хүнд сурталгүй чанарын хяналтын системийг нэвтрүүлнэ</p> <p>Албан бус үр үржүүлэгчдийн зүгээс өвчнийг тархаахгүй байх арга хэмжээ авна.</p> <p>Чанартай үрийн үр ашиг ихэнх фермерүүдэд илт мэдрэгдэнэ</p> |
| <p><b>Бүтээгдэхүүн</b></p> <p>1.1 Лабораторуудын өвчлөлгүй бэсрэг булцуу үйлдвэрлэлийн өртөг буурна</p> <p>1.2 Үрийн доройтлын судалгаан дээр үндэслэн чанартай үрийг шаардлагатай газар нь, хүрэлцээтэй хэмжээгээр, үр ашигтай үйлдвэрлэх асуудлыг шийдвэрлэнэ</p> <p>1.3 Албан бус үр үржүүлэгчид хэрэгцээн дээр үндэслэсэн тогтвортой, чанартай үр үйлдвэрлэл явуулах хүчин чадал нь нэмэгдэнэ</p> <p>1.4 Жижиг фермерүүдийг чанартай үрээр хангах механизм, үрийг хамгийн үр ашигтайгаар хэрэглэх стратегийг түншүүдийн хамт илрүүлж олно.</p> <p>1.5 Монголын нөхцөлд тохирох төмсний шинэ сортуудыг сонгон шалгаруулж, үржүүлж эхэлнэ</p> | <p>2009 онд 2007 оны өртөгөөр доод тал нь 200000 булцуу үйлдвэрлэнэ</p> <p>Халдвараас бүрэн чөлөөлөгдсөн эрүүл булцуу үйлдвэрлэнэ.(2008)</p> <p>Тогтолцоо нь үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдийн шалгуурт тохирсон байна (2009)</p> <p>200 төвлөрсөн бус албан бус үр үржүүлэгчид 2009 онд 1600тн чанартай үрийг үйлдвэрлэж, борлуулна</p> <p>2010 онд нийт төмс тариалагчдын 30% нь чанартай үр хэрэглэнэ</p> <p>2011 онд Импалагаас давуу 3 сортыг нэвтрүүлж, тус бүрээс нь 10тн үр үйлдвэрлэнэ</p> | <p>Жилийн тайлан, өрт зардлын тооцоо, төслийн тайлан</p> <p>Төслийн жилийн тайлан</p> <p>Төслийн жилийн тайлан</p> <p>Түншүүдийн тайлан (Төслийн жилийн тайлан)</p> <p>Төслийн жилийн тайлан</p> |   |

|                     |   |  |  |  |
|---------------------|---|--|--|--|
|                     | <b>Үр дүн 2:</b> Оновчтой технологи дэлгэрүүлэх, оролцоонд тулгуурласан хөгжлийг бий болгосноор төмс үйлдвэрлэгчид эдийн засгийн үр ашгаа нэмэгдүүлэх чадавхиа бэхжүүлнэ.   | Төмс үйлдвэрлэгчдийн 20% нь доод тал нь нэг шинэ технологи, аргыг эзэмшинэ (2011)  | Судалгаа   | Түншүүд нь чадамжийн хувьд шинийг сэдсэн, бөгөөд фермерүүдийн нөөц бололцоо ба хязгаарлах хүчин зүйлд мэдрэмжтэй байх                            |
| <b>Бүтээгдэхүүн</b> | 2.1. Оролцооны арга дээр түшиглэн зорилтот бүлэг тус бүрийн онцлогт тохирсон илүү үр ашигтай, тогтвортой үйлдвэрлэлийн аргуудыг нэвтрүүлнэ<br><br>2.2 Ирээдүйтэй, байгаль орчинд ээлтэй технологийг өргөн хүрээнд дэлгэрүүлнэ/нэвтрүүлнэ    | 3-аас доошгүй ядуу зорилтот бүлгийн фермерүүдийн 50% нь судалгаа шинжилгээний ажилд оролцож, доод тал нь нэг аргыг эзэмшинэ<br><br>Фермерүүд өөрсдийн боломжид тулгуурлан туршилтыг үргэлжлүүлэн хийнэ<br><br>Санамсаргүй сонголтоор сонгож авсан хүмүүсийн 30% нь өөрсдийн хамрагддаг зорилтот бүлгийн оновчтой аргуудыг сурч мэднэ | Түншүүдийн нөлөөллийн мониторингийн тайлбар<br><br>2011 оны судалгаа | (Засгийн газар болон банкууд хөрөнгө оруулалтын зээл олгох зөвшилцөлд хүрнэ)   |
|                     | <b>Үр дүн 3:</b><br>Төмсний хангалтын сүлжээг сайжруулж, ашиг нэмэгдүүлэх сонголтыг бий болгоно   | Хөдөө орон нутагт төмсний хүрэлцээг нэмэгдүүлж, 2011 онд хөдөөгийн хүн амын төмсний хэрэглээг 30%-аар, хот суурин газарт 10%-аар тус тус нэмэгдүүлнэ   | Суурь судалгаа<br>2011 оны судалгаа                                  | Хангалтын сүлжээний оролцогч талууд нь хамтарч ажиллахад бэлэн байна   |
|                     | 3.1 Хот, хөдөөгийн хүн амын хүнсэнд төмсний эзлэх байр суурийг судлан шинжилж, хандлагыг тодорхойлно<br><br>3.2 Хангалтын сүлжээг холбогдох оролцогч талуудын хамт шинжлэн хэрэглээг нэмэгдүүлэх, сайжруулах боломжтой аргуудыг туршиж үзнэ | Үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдэд хүлээн зөвшөөрөгдөх судалгаа/шинжилгээ явуулна<br><br>Доод тал нь 4 борлуулалтын сүлжээнд төмсний хэрэглээг 30%-аар нэмэгдүүлнэ  | Судалгааны талаарх санал хүсэлт<br><br>Төслийн жилийн тайлан         | Хэрэглэгчид нь ашиг нэмэгдүүлэх, сонголт бүхий ирээдүйтэй сортуудыг худалдан авах талаар мэдээлэлтэй байна                                       |
|                     | <b>Үр дүн 4:</b><br>Гол оролцогч талууд (үйлдвэрлэгчээс ба хэрэглэгч хүртэл)-ын үр ашигтай харилцан ажиллагаанд дөхөм болох төслийн хамрах хүрээ, бодлогыг тодорхойлохын тулд хамтын ажиллагаа, хүчин чадлаа сайжруулна/бэхжүүлнэ           | 2011 онд төмсний үндэсний Зөвлөл байгуулагдана<br><br>2010 он гэхэд ихэнх төмс тариалагчидтай холбоотой бодлого, хүрээнд нэг томоохон дэвшил/сайжруулалт гаргана.  | Үндсэн баримт,<br>Хэвлэл мэдээлэл, төслийн жилийн тайлан             | Оролцогч талууд ТҮЗ-тай хамтран ажиллахад бэлэн байх нь гишүүдэд үр ашигтай байдлыг нотлон харуулна. ТҮЗ-ийг хэрхэн санхүүжүүлэх арга замыг олно |
|                     | 4.1 Төслийн Зохицуулах хорооны үйл ажиллагааг гүнзгийрүүлж, Төмсний Үндэсний Зөвлөл болгон хөгжүүлнэ  | Төслийн хамрах хүрээнд томоохон дэвшил гаргана<br>Гишүүдийн идэвхтэй оролцоо (2008-2011)   | Зохицуулах хорооны хурлын тайлан                                     |  |

### Хүснэгт 6-ийн үргэлжлэл: “Монгол төмс” төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө-Төслийн 2-р үе шат- Менежмент

| Менежментийн бүтээгдэхүүн  | Үзүүлэлт  | Нотолгоо                     | Чухал таамаглал                            |
|--|---|------------------------------|--|
| <b>Хүний нөөц/Боловсон хүчний асуудлыг зохицуулна</b>  |   |                              |  |
| ХУН нь орон тоо, боловсон хүчний сонголтыг хийнэ   | 2008 онд төслийн бүрэлдэхүүн хэсэг бүр хариуцсан мэргэжилтэнтэй болно.(Нэг ажилтан нэмж авна)               | Жил бүрийн удирдлагын тайлан | Тохирох боловсон хүчнийг сонгон ажиллуулна |
| Бүх ажилтнуудад тодорхой зорилтуудыг оноож өгнө  | 2008 он гэхэд ажил үүргийн бодитой хуваарийг мөрдөнө  | Зорилтын хуваарь             |  |
| Зохицуулагч нь үйл ажиллагаагаа удирдан явуулах хангалттай цаг гаргана                         | Тайланг хугацаанд нь чанартай гаргана   | ШХА-ийн санал хүсэл          |  |
| ХУН-ы техникийн болон менежментийн чадавхийг улам сайжруулна                                   | Чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлнэ  | Жил бүрийн удирдлагын тайлан |  |
| Аймаг орон нутгийн төлөөлөгчдийн техникийн болон менежментийн чадавхийг сайжруулна             | Орон нутгийн төлөөлөгчид нь албан бус үр үржүүлэгчдэд үзүүлэх зөвлөх үйлчилгээний дунджаар 80%-ийг хариуцна | Жил бүрийн удирдлагын тайлан |  |
| Аймгуудын орон нутгийн төлөөлөгчдийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зохистой арга хэмжээг авна | Төслийн зохицуулагчийн чанарын үнэлгээ  | Жил бүрийн удирдлагын тайлан |  |
| <b>Санхүүгийн нөөцийг зохицуулах</b>   |   |                              |  |
| Төсвийн гүйцэтгэлийг дүрэм журмын дагуу хийнэ  | Төсвийн хазайлт/хэтрэлт 10%-аас хэтрэхгүй байна (ШХА-иас батлуулаагүй бол)                                  | Төсвийн гүйцэтгэлийн тайлан  |  |
| Санхүүгийн үйл ажиллагаа зохих дүрэм журмын дагуу үнэн зөв явагдана                            | Аудитийн зэрэг тайлан   | Аудитийн тайлан              |  |
| <b>Гадаад харилцааг зохицуулах</b>   |   |                              |  |
| Бусад донор байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг нээн илрүүлнэ                           | 2008 онд ХАА-н салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бүх донор байгууллагуудтай холбоо тогтооно         | Жил бүрийн төслийн тайлан    |  |
| Төвлөрсөн бус шатанд судалгаа шинжилгээний түншлэлийг бий болгоно                              | 2009 он гэхэд 6 гэрээнд гарын үсэг зурна  | Төслийн баримт бичиг         |  |
| Төмсний Олон Улсын Төвийн гадаадын зөвлөх үйлчилгээг нэмэгдүүлнэ                               | Жил бүр тодорхой хөтөлбөрийн дагуу 3 мэргэжилтэн ажиллана   | Төслийн жил бүрийн тайлан    |  |
| <b>Дотоод харилцааг зохицуулах</b>   |   |                              |  |
| ХУН-ы ажилтнуудын мэдээлэл солилцох явдлыг баталгаажуулна                                      | Ажилтнуудын хурал жилд 10 удаа  | Протокол                     |  |
| Салбарыг Зохицуулах хороонд амжилттай төлөөлнө   | Бүх оролцогч талуудыг оролцуулан  | Протокол                     | Шинэ гишүүдийг сонгоно                     |

|   |  |                                |                           |
|---|--|--------------------------------|---------------------------|
| Зохицуулах хороо нь хүлээгдэж буй үр дүнд хүрнэ   | Зохицуулах хорооны хуралд бүх гишүүд идэвхтэй оролцоно         | Зохицуулагчийн чанарын үнэлгээ | Идэвхгүй гишүүдийг солино |
| <b>Мэдлэгийн менежемент</b>   |  |                                |                           |
| Мониторингийн хэрэгслийг бий болгож, хэрэглэнэ  | Мониторингийн мэдээ цуглуулна                                  | Мониторингийн тоон мэдээ       |                           |
| Төслийн баг нь мониторингоор илэрсэн сул тал, урган гарч буй хэрэгцээ шаардлагад хариу өгнө | Асуудлыг төслийн багийн хурлаар хэлэлцэнэ                      | Төслийн багийн хурлын протокол |                           |
| Дотоод үйл ажиллагааны баримтжуулалтыг сайжруулна   | Туршилт- үзүүлэнгийн талбайд хийгдсэн ажлыг бичиг баримтжуулна | Төслийн жил бүрийн тайлан      |                           |
| Үр дүн, сургамжуудын талаар оролцогчидтой ярилцаж зөвлөлдөх ажилд ахиц гаргана              | Төслийн үйл ажиллагааны талаар орон даяар мэдээлэлтэй болно    | ШХА-ийн чанарын үнэлгээ        |                           |
| Төмсний салбарт хүйсийн тэгш байдал бий болно   | 2009 онд мэдээллийн тайланг гаргана.                           | Жендерийн тайлан               |                           |
| Өөрийгөө үнэлэх арга барил, чадвар сайжирна   | Төсөл жил бүр өөрийн үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ             | Хөндлөнгийн үнэлгээ            |                           |

## **2.4.Түншүүдийн стратегитай хамааралтай болон нийцтэй байдал**

Төмс нь ердийн таримлууд болон хүнсний ногоонуудын дотроос ач холбогдол, хэрэглээ, тохиромжтой байдлаараа илт ялгарна. Жижиг аж ахуйд гар аргаар тариалах боломжтой (үр тариаг бодвол), өртөг багатай, харьцангуй тэсвэртэй хүнсний таримал бөгөөд бусад хүнсний ногоотой харьцуулбал их хэмжээний энерги, уургийн агууламжтай хүнсний ач холбогдлоороо өндөр байдаг (Horton, 1987).

Ийм учраас төмс нь дэлхий даяар хүн амын ядуу хэсэгт ээлтэй, тэдний тариалж, хүнсэндээ хэрэглэдэг үнэ цэнэтэй гол таримал болно. Үүнээс гадна хүн амын эдийн засгийн хувьд боломжтой хэсгийн хүнс тэжээлийг баяжуулж, өндөр чанартай боловсруулсан тусгай хэрэгцээний бүтээгдэхүүн (төдийлөн эрүүл хүнс биш боловч) болж хувирдаг (франц шарсан төмс, чипс г.м).

Нөгөө талаар, хяруу, ган, халуун зэрэг байгалийн эрсдэлд өртөмтгий, ургамлын элдэв өвчний ялангуяа фитофтор өвчний улмаас ургац алдах магадлал өндөртэй, нэг га-д орох үрийн хэмжээ их учраас өртөг өндөр, хадгалалтын зардал ихтэй зэрэг нь төмсний үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлж, эрсдлийг ихэсгэдэг.

Төмсний үйлдвэрлэлийн эдгээр онцлог шинжээс хамаарч төслийн 2-р үе шатанд санал болгож буй оролцооны стратеги нь төслийг Монгол улсын Засгийн газрын болон ШХА-ийн бодлого, стратегитай холбон уялдуулж өгч байна.

Нөгөө талаар төслийн эрсдлийн мониторинг хийх зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм.

### **Ядуурлыг бууруулах**

Төсөл нь 2-р үе шатандаа шинээр бага хэмжээний талбайд төмс, хүнсний ногоо тариалж амьдрал ахуйгаа залгуулж байгаа эмзэг бүлэг (өмнө нь мал аж ахуй эрхэлж байсан)-ийн фермерүүдэд онцгой анхаарал хандуулж ажиллана: Эдгээр зорилтот бүлгүүдтэй хамтран оролцооны аргаар үржүүлж буй үрийн чанар байдлыг судалж, жижиг аж ахуйд үр үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг сайжруулах, үйлдвэрлэсэн үрийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх тохиромжтой стратегийг боловсруулна.

Жижиг фермерүүдийн хүчин чадал, боломж нөхцлийг харгалзан тэдэнд ашигтай байж болох бусад технологиудын хамтран судалж хэрэгжүүлнэ. Зохицуулах хороонд төмс тариалагчдын хамгийн эмзэг бүлгийн төлөөллийг урьж оролцуулснаар тэдний санал, дуу хоолойг төслийн удирдлага, менежментэд өргөн тусгаж, үр дүнтэй бодлого боловсруулах боломжтой болно.

Жижиг фермерүүдийн ихэнх нь зөвхөн өөрсдийн хэрэгцээндээ зориулж, тэжээллэг чанарыг сайжруулахын тулд төмс тариалдаг боловч тэдний зарим нь тариалсан төмсөө орон нутгийн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын тусгай сүлжээнд нэгдэн орох боломжтой юм.

Төсөл нь төмсний салбарын хөгжил дэвшилд бүхэлд нь нарийн мониторинг хийж, жижиг тариаланчид орлогын эх үүсвэр олох үйл ажиллагаанд хамрагдаж буй эсэх, том үйлдвэрлэгчдэд шахагдаж буй эсэхийг хянана. Энд яригдаж буй гол стратеги нь төвлөрсөн бус хөндлөнгийн оролцооны асуудал юм.

### **Орлогын эх үүсвэр бий болгох**

Төмс тариалснаар жижиг талбайгаас ихээхэн ашиг орлого олох боломжтой (Нөгөө талаар эрсдэл өндөртэйг дурьдах хэрэгтэй) бөгөөд гэхдээ энэ нь зөвхөн эрэлт хэрэгцээ их байгаа нөхцөлд хэрэгжинэ.

Төслийн нэг гол анхаарах зүйл нь төмсний хэрэгцээ бага байгааг нэмэгдүүлэх явдал бөгөөд Монгол хүний хүнсний хэрэглээнд төмсний эзлэх хувийн жин харьцангуй бага юм. Мөн хөдөө, хотын хүн амын дотор төмсний хэрэглээний үлэмж ялгаа бий. Гэтэл Монгол улс 2000-2005 онд төмсний хэрэгцээнийхээ 30-40%-ийг Хятадаас импортлон авч байснаа 2006 онд өндөр ургац авсан учраас энэ байдал өөрчлөгдөж, импорт 20% болж буурсан байна.

Гэхдээ Монгол улсын хувьд зөвхөн 8-9-р сард ургац хурааж авдаг бөгөөд тийнхүү хурааж авсан төмсөө 10 сарын туршид муутгахгүйгээр хадгалах нь бэрхшээлтэй асуудал учраас дээрх 20%-ийн импортийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангах бараг боломжгүй юм.

Ирэх жилүүдэд өндөр ургац авснаар үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, үндэсний үйлдвэрлэлээр төмсний эрэлт хэрэгцээг хангах боломж бүрдэх боловч үүнтэй холбоотойгоор үнэ унах, хадгалалтын зардал нэмэгдэх эрсдэл гарч ирнэ гэдгийг анхаарах хэрэгтэй.

Иймээс төсөл нь салбарыг үр ашигтай байлгаж, ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд хэрэглээг нэмэгдүүлэх шаардлага гарч ирнэ.

Ингэхийн тулд борлуулалтын сүлжээнд ухаалаг зохицуулалт хийх нь чухал.

Энэ нь хөрөнгө оруулалтын үр ашиг, нөхөн төлөгдөлт болон орлого үүсгэх чадамжийг хязгаарлах нэг хүчин зүйл мөн.

### **Хүнсний аюулгүй байдал ба тэжээллэг чанар**

Төмсний үйлдвэрлэл нь харьцангуй өндөр эрсдэл дагуулдаг боловч түүнийг төвлөрлөөс гаргаж чадсанаар хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулж чадахсан. Төслийн эхний үе шатанд төвлөрсөн бус үр үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгох эхлэлийг тавьсан бөгөөд цаашид тариалангийн төвийн бүсээс хальж (одоогоор төмсний 80%-аас илүү хувийг үйлдвэрлэдэг) бусад бүс нутгууд дахь үйлдвэрлэлд илүү анхаарал хандуулж ажиллана.

Ингэж орон нутгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр импортоос хамаарал багатай болно. Төмс нь хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах чадамж өндөртэй бөгөөд бусад хүнсний бүтээгдэхүүнийг бодвол С витамин, эрдэсийн агуулга өндөртэй байдаг.

Мөн төмсөнд өөх тос, энергийн агууламж бага байдаг нь мах ихтэй хоол хүнсэнд хамгийн тохиромжтой нэмэгдэл болж чадна. Ялангуяа хот суурин газарт төмс нь тэжээллэг чанараас шалтгаалсан эрүүл мэндийн эрсдлийг бууруулахад тус дөхөм болж чадна гэж үзэж байна (Хэрэв бэлтгэх явцад тос хэрэглээгүй бол).

Төсөл нь хэрэглээг нэмэгдүүлэн, зах зээлийн сүлжээг сайжруулахын тулд үйлдвэрлэлийн ашигтай байдлыг хангах, хүн амын хүнсний тэжээллэг байдлыг сайжруулах 2 зорилт тавин ажиллана:

Хачирхалтай нь хөдөөгийн хүн амын ихэнх хэсэг ялангуяа малчид төмсийг маш бага хэмжээгээр хэрэглэдэг нь ажиглагдсан.

Тэд хүнсэндээ төмс хэрэглэхийн ач холбогдлын талаар маш бага мэдээлэлтэй байдгаас бага хэрэглэдэг байж болно. Мөн тэдэнд өвлийн цагт төмс хадгалан хэрэглэх боломж байдаггүй нь хэрэглээг хязгаарлах гол хүчин зүйл болно. Тэдний цөөн хэд нь төмс үйлдвэрлэлийн салбарт нийтлэг байдаг энгийн нүхэн зорьтой байдаг. Өөр нэг шалтгаан нь малчид зах зээлээс (сумын төвөөс) алслагдмал амьдардаг явдал юм.

Иймд хөдөөгийн хүн амын ялгаатай бүлгүүдийн төмсний хэрэглээний хэв маягийг судалж, тэднийг энэхүү үнэ цэнэтэй хүнсний бүтээгдэхүүнээр хангах орон нутгийн стратегийг өөрсдийнх нь оролцоотойгоор боловсруулах явдал төслийн нэг зорилт болж байна

### **Байгалийн нөөцийг хамгаалах**

Монгол орны байгалийн нөөц нь харьцангуй өндөр эрсдэлд оршиж байна (Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжүүлэх статусын үндэсний тайлан).

Газрын болон бэлчээрийн доройтол, агаарын бохирдол ихсэж байгаа, эрчим хүчний зарцуулалт нь ашиг багатай, ой мод огтлолт, байгалийн нөөцийг замбараагүй ашигласнаас биологийн төрөл зүйл ядуурч буй зэрэг нь байгаль орчны ноцтой асуудлуудыг үүсгэж байна.

Төмсний үйлдвэрлэл ба маркетинг нь механикжуулалтын түвшин өндөр, тээврийн зардал ихтэй, өвлийн улиралд зоорийг халаах эрчим хүчний зардал өндөртэй байдаг нь байгалийн нөөцийн алдагдалд нөлөөлдөг. Төслийн анхаарал хандуулах хоёр дахь томоохон асуудал бол хадгалалтын системийг илүү оновчтой болгох асуудал юм.

Жижиг үйлдвэрлэгчдэд (ихэвчлэн гараар тариалдаг) анхаарал хандуулснаар төмс үйлдвэрлэлийн нийт шаардлагатай түлш шатахууны хэрэглээг багасгаж болох боловч төвлөрсөн бус үйлдвэрлэл, хэрэглээг бий болгохыг зорьж байгаа учраас борлуулалтын сүлжээг тэнцвэржүүлсэн ч тээврийн хэрэгцээг багасгах бараг боломжгүй юм.

Зарим оролцогчид хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахыг зорьж, энэ чиглэлээр зарим үйл ажиллагаа төлөвлөж байгаа бөгөөд энэ нь пестицидийн хэрэглээг багасгах боломж олгоно. Тэдний хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах амлалт үүрэг нь өргөн хүрээнд нөлөөлөх боломжтой.

Услалтын системийг нэвтрүүлэхдээ хөрсний давсжилт, гүний усны нөөц хомсдох эрсдэл зэргийг сайтар тооцож, үндэслэлийг тодорхой гаргах шаардлагатай.

## **Засаглал**

### **Хүйс**

Төсөл нь фермерүүдтэй хамтран ажиллахдаа хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахад тодорхой анхаарал хандуулж ажилласан. Одоогийн байдлаар 60 эрэгтэй, 30 эмэгтэй албан бус үр үржүүлэгчид сонгогдон ажиллаж байна.

Гэхдээ эдгээр фермерүүдийн олонхи (80%) нь агрономичид учраас жижиг фермерүүдийн төлөөлөл төдийлөн болж чадахгүй бөгөөд төслийн 1-р үе шатан дахь зорилтот бүлгийн тоо харьцангуй цөөн, шинэ технологи, шинэ сорттой ажиллахад дөхөмтэй байдлыг харгалзан мэргэжлийн давуу байдлыг эрхэмлэн сонголт хийсэн

Төсөл нь 2-р үе шатандаа янз бүрийн зорилтот бүлгүүдийн олон фермерүүдтэй хамтарч ажиллана (шууд юмуу бусад түншүүдээр дамжуулан).

Төмсний салбарын болон хүнсний тогтолцооны судалгаагаар харилцан ялгаатай зорилтот бүлгүүдийг тодорхойлж, эрэгтэй, эмэгтэй фермерүүдийн талаарх мэдээлэлд тус тусад нь дүн шинжилгээ хийнэ.

Ингэснээрээ төсөл нь эрэгтэй, эмэгтэй, хүйсийн фермерүүдтэй хамтарч ажиллах тактик, арга замыг оролцооны аргаар боловсруулан шийдвэрлэх боломжтой болно.

Бүрэн туршлагажаагүй фермерийн тогтолцооны судалгаанд үйл ажиллагааны хуваарийн дагуу хүйсийн шинжилгээ хийх, нөөцийн хүрэлцээ ба хяналт, үр ашиг, оролцоог төлөвлөх, хүйсийн шинжилгээний сургалт зэргийг хамруулна.

Технологийн үйл явцад хүйсийн мэдрэмтгий байдлыг нэмэгдүүлнэ.

Нэвтрүүлсэн үйлдвэрлэлийн аргуудын нийгмийн нөлөөг тогтмол үнэлж, нийгмийн сөрөг нөлөө бүхий аргуудыг (хүйсийн тэнцвэргүй байдлыг нэмэгдүүлэх) орхих, солих зэрэг арга хэмжээ авна.

Мөн борлуулалтын сүлжээний үйл ажиллагаанд жендерийн асуудал чухлаар тавигдах болж байна.

### **Эрх мэдэл олгох**

Төсөл нь оролцооны аргад түшиглэн шаардлагатай судалгаа шинжилгээ эхлүүлж, оновчтой технологийг нэвтрүүлнэ.

Эдгээр үйл ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүн нь зорилтот бүлгийн хүчин чадал, нөхцөл байдалд зохицсон, тэдний хэтийн төлөв, хэрэгцээ шаардлагад сайтар нийцсэн байх нь зөв.

Төслийн эцсийн зорилго нь төсөл дууссанаас хойш фермерүүд бие даан үйл ажиллагааг үргэлжлүүлэн авч явах, асуудлаа өөрсдөө шийдвэрлэх чадвартай болгох явдал юм. Энэ нь мөн тэдний холбогдох оролцогч талуудтай зөвшилцөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

## **Гадаадын мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллах (өмнөд өмнөдийн зарчмаар)**

Төсөл нь ТООТ-ийн мэргэжилтнүүдээс гадаадын зөвлөх үйлчилгээ авах, түншүүдийнхээ чадварыг бэхжүүлэх, генетик материал олж авах үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

Мөн Хятадын төмсний чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай цаашид хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ.

Төслийн өргөн хүрээний төлөвлөгөөнд Өмнөд-өмнөдийн хамтын ажиллагааны шинэ шаардлагуудыг тусган хэрэгжүүлнэ. Олон улсын төрийн бус байгууллагуудтай төвлөрсөн бус байдлаар хамтран ажиллах, Өмнөдийн бусад шинэ туршлагаудаас суралцах үүд хаалга нээгдэнэ.

## **Ахиц дэвшил ба эрдэм шинжилгээ нэвтрүүлэх ажлын уялдаа**

Төслийн зүгээс санаачлан хэрэгжүүлж байгаа үр үйлдвэрлэлийн тогтолцоо нь улсын хэмжээнд бүх бүс нутгийг хамрах зорилго тавьж байгаа юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд албан бус үр үржүүлэгчдээр дамжуулан төмсний үр үйлдвэрлэн-хэрэглэгчдийн шууд харилцааг хэрэгжүүлж, төмсний тариаланг бүхэлд нь сайн чанартай үрээр хангана.

Ингэж сайн чанарын үр, шинэ сортын ач тусыг түргэн хүртэх боломжийг олон нийтэд тэгш олгоно. Шинэ сорт ба үр үржүүлгийн ажлын ахиц дэвшил нь маш өндөр бөгөөд аль хэдийн өргөн хүрээнд хэрэгжээд байна. Жижгэвтэр, жижиг фермерүүд төмсний үрийг хамгийн үр ашигтай байдлаар ашиглах арга замыг нээн илрүүлэх, ашиглах боломж бүрдэнэ

Иймээс зорилтот бүлэг тус бүрд ахиц дэвшил гаргахын тулд чиглэгдсэн стратеги (өөр өөр зорилтот бүлгүүдэд ялгаатай стратеги боловсруулах) хэрэглэх шаардлагатай.

Чиглэгдсэн стратегийг боловсруулахдаа бүс нутаг, хязгаар бүрт төмсний үйлдвэрлэлийн бусад асуудлууд (хөрс, усны менежмент, арчилгаа, бордоо хэрэглэх, ургамал хамгаалал г.м) харилцан адилгүй байдгийг харгалзан үзэж, тус тусад нь тохирсон байдлаар боловсруулан мөрдүүлэх шаардлагатай

Энэ нь цөөн хэдэн онцгой хамааралтай асуудлыг сонгон хэрхэн амжилттай дэвшил гаргахыг илрүүлж олоод, түүндээ хүрэх явдал юм.

Хөтөлбөр нь түншүүдийнхээ дунд туршлага солилцох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Зарим дэвшилттэй үйл ажиллагааг эрчимжүүлж, түгээн дэлгэрүүлнэ.


Ихэнх нь бусад оролцогч талуудад (ТББ-иуд, экстейншний үйлчилгээ) үйлчлэх ба фермерүүд ТББ-ын дэмжлэгтэйгээр ялгаатай асуудлуудаар үнэлгээ өгч, судалгаа явуулна. Үүний адил, борлуулалтын сүлжээг сайжруулахын тулд тодорхой тохиолдлуудыг сонгон авч, зэрэглэлийг дээшлүүлэх шаардлагатай. Ингэхлээр төслийн хамрах хүрээ ба хамрах хүрээний бус асуудлуудад хамтын хүчийг ашиглан зангидсанаар төмсний үр болон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээ, борлуулалт, боловсруулалтын бүх салбарт ахиц дэвшил гаргах боломжтой

## 2.5. Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа

Гарах үр дүнд хамаарагдах төлөвлөсөн бүтээгдэхүүн, үйл ажиллагааг бүлэглэн үзүүлэв. Үйл ажиллагаануудыг нарийвчилсан байдлаар Хавсралт 1-д үзүүлэв (Нөөцийн төлөвлөлт, төсвийг үйл ажиллагаагаар).

### Үр дүн 1: Шинэ сортууд, үр үйлдвэрлэл

Үр дүн 1-д хамаарагдаж байгаа ялгаатай бүтээгдэхүүнүүд нь хоорондоо холбоотой (Зураг 5). “Үрийн хэрэглээ” шинэ бүрэлдэхүүн хэсгийн үр дүн (бүтээгдэхүүн 1.4) нь үржүүлгийн схемийн хэлбэрт нөлөөлөх ба (зорилтот хэмжээ юмуу ангилал бүрийн үр, чанарын стандарт, янз бүрийн хэсгүүдийн хоорондын уялдаа холбоо) .1,1, 1.2 ба 1.3-ийн бүтээгдэхүүнд нөлөөлнө.



### Зураг 5: Үр үйлдвэрлэл, ба шинэ сортоос хамаарсан харилцан адилгүй бүтээгдэхүүнүүдийн хоорондын уялдаа холбоо

Чанартай үрийн хэрэгцээг тооцож гаргах нь бэрхшээлтэй бөгөөд хэдэн мянган жижиг фермерүүд үрийг хэрхэн хэрэглэх нь тодорхойгүй байна.

Дараах тооцоо нь 2 боломжит хувилбар дээр үндэслэсэн болно:

а) Түргэвчилсэн үр шинэчлэл: Хэрэглээний төмс үйлдвэрлэгчид нь нийт тариалангийн талбайдаа 3 жил тутамд чанартай үр худалдан авна; б) Өртөг хэмнэх зорилгоор үр шинэчлэлийг аажим явуулах: Хэрэглээний төмс үйлдвэрлэгчид нь нийт талбайн тодорхой хэсэгт зориулж 3 жил тутамд чанартай үр худалдан авах ба худалдан авсны дараагийн жилд нийт тариалангийн талбайдаа тариалах үртэй болохын тулд үр үржүүлнэ. (Зураг 6). Түргэвчилсэн үр шинэчлэлийн хувилбарт чанартай үрийн хэрэгцээ дунджаар хэрэглээний төмсний га-д нэг тн байх бол өртөг хэмнэх хувилбарт (б) чанартай үрийн хэрэгцээ дунджаар хэрэглээний төмсний га-д 0.2тн байна.

Дэлхийн зарим хэсэгт (Анд, Гималай) үрийн доройтол удаан явагддаг онцлогийг ашиглан жижиг фермерүүд нь ихэвчлэн өртөг хэмнэх зорилгоор үр шинэчлэлийг аажим явуулах хувилбарыг сонгодог байх юм.


Энэ хувилбар нь зөвхөн бага хэмжээний үр худалдан авах асуудал биш тээвэр, ажил хэргийн зардлыг ч хэмнэдэг учраас Монголд ч мөн адил чухал байж болох юм.

Гэхдээ үр үнэгүй юмуу хөнгөлөлттэй үнээр олгогддог бол (Монголд хэд хэдэн ТББ хэрэгжүүлж байгаагийн адил) фермерүүд түргэвчилсэн үр шинэчлэлийн хувилбарыг сонгох нь дамжиггүй.

Ирээдүйтэй, шинэ сортыг нэвтрүүлж байгаа тохиолдолд хүн бүр зэрэг үрээ шинэчлэх гэж хичээх нь мэдээж учраас үрийн хэрэгцээ ихэсч үнийн зохиомол хөөрөгдөл газар авах эрсдэлтэй.

Ийм тохиолдолд эхний жилдээ үрийн эрэлт хэрэгцээг хангах боломжгүй болно гэсэн үг.

**Зураг 6: Арилжааны зорилгоор үр үйлдвэрлэгчид чанартай үр хэрэглэхийн тулд сонгох 2 хувилбар** (0.33 га-д төмс тариалдаг фермерүүдэд хувьд тооцож үзвэл)



Нэмж хэлэхэд, бүх фермерүүд нь чанартай үр тариалах сонирхолтой, боломжтой байх нь бодитой биш үзэгдэл юм.

Иймээс гурав дахь хувилбар нь (а), (б)-ийн дундах (в) "Best bet" хувилбар бөгөөд энэ (а)-аас илүү, (б)-тэй ойролцоо байна (Хүснэгт 7)

Нэлээд хуучныг баримталсан таамаглалаар (үрийн ургац зөвхөн 8тн/га, үржлийн итгэлцүүр 5) " Best bet " хувилбарын дагуу элит үрийн хэрэгцээ жилд зөвхөн 300тн байна гэсэн үг. Албан үр үйлдвэрлэлийн одоогийн хүчин чадал нь сайнаар бодоход ийм хэрэгцээг хялбархан хангаж болохоор харагдаж байна.

Түүгээр барахгүй “түргэвчилсэн шинэчлэл” хувилбараар хэрэгцээг хангаж болохуйц харагдаж байгаа боловч энэ нь элит үрийн хэт үйлдвэрлэлийг бий болгож болох юм. Тиймээс албан үр үйлдвэрлэлийн гол зорилго нь илүү үр ашигтай, өөрийгөө санхүүжүүлэх чадвартай, эрүүл, өртөг багатай, чанарын баталгаатай болгоход оршино.

**Хүснэгт 7: Дээрх 3 янзын хувилбарын дагуу өөр өөр ангиллын чанартай үрийг үйлдвэрлэсэн улсын нийт хэрэгцээ**

|  | Хувилбар           |             |                 |
|--|--------------------|-------------|-----------------|
|  | а) Түргэн шинэчлэл | б) Best bet | в) Өртөг хэмнэх |
| Чанартай үрийн жилийн дундаж хэрэгцээ (тн)   | 10'000             | 4'000       | 2'000           |
| Албан бус үр үржүүлэгчийн ийм хэмжээний үр үйлдвэрлэл явуулахад шаардагдах талбай (га) | 1250               | 500         | 250             |
| Албан бус үр үржүүлэгчийн элит үрийн хэрэгцээ (тн)                                     | 700                | 300         | 150             |

Таамаглал Монголын нийт төмс тариалах талбай- 10000га

1 Албан бус үр үржүүлэгчид нь дунджаар 8тн/га-ийн үрийн ургац авна

2 I Албан бус үр үржүүлэгчид нь үрээ 2 жил тутамд шинэчилж, энэ зорилгоор нийт тариалангийн талбайнхаа 1/5-д элит үр худалдан авч тариалах бөгөөд шинэчлэх зорилгоор тариалах га тутамд 0.6тн Элит үр шаардагдана

**1.1 Лабораториуд өртөг хэмнэсэн, үр ашигтай байдлаар өвчлөлгүй бэсрэг-булцуу үйлдвэрлэнэ**

1. Бэсрэг-булцууны үйлдвэрлэлийн өртгийг бууруулах

Үржлийн итгэлцүүрийг нэмэгдүүлэх, хамгийн шилдэг технологи нэвтрүүлэх, хүлэмжийн менежментийг сайжруулахын тулд гидропоник, аэропоник аргуудыг туршин, нэвтрүүлэх

2. In-vitro үйлдвэрлэлийн схемийг хянаж үзэх

Шингэн тэжээлт орчинг үнэлэх, бага өртгөөр олон ургамаланцарууд үйлдвэрлэх

3. Лаборатори ба хүлэмжинд явуулах чанарын хяналтыг сайжруулах, хэрэгжүүлэх

Вирусын халдвар, дахин халдварлахаас бүрэн ангижирсан байдлыг баталгаажуулах

4. Үйлдвэрлэлийн тогтвортой үйл явцыг бий болгох

Жишээ нь, шилэн хүлэмж барих, халаалтын системийн үр ашигтай байдлыг үнэлэх

5. Хүлэмж, лабораторийг өргөн хэрэглээний эд зүйлсээр үргэжлүүлэн хангах

Хүрээлэнгүүд өөрсдийгөө санхүүжүүлэх механизмтай болтол үргэжлүүлэн эм урвалж болон лабораторийн өргөн хэрэглээний багаж төхөөрөмжөөр хангах шаардлагатай.

## **1.2 Үрийн доройтлын судалгаан дээр үндэслэн чанар сайтай, хүрэлцээтэй хэмжээний албан үрийг шаардлагатай газар нь үр ашигтай замаар үйлдэрлэх схем**

### **1. Талбайн үржлийн итгэлцүүрийг нэмэгдүүлнэ**

Жишээ нь, тарих нормыг өөрчлөх, ихэсгэх зэргээр үйлдэрлэлийн энгийн туршилтуудыг хийнэ (га дахь үрийн хэмжээг ихэсгэх)

2. Үрийн бүх талбайн өвчний халдварын хяналт тавьж, халдвар тархах замыг хаана.

Албан болон албан бус үржүүлэгчдийн үрийн талбайд ямар стандарт хамгийн тохиромжтой, үйлдвэрлэлийн ямар нөхцлүүд доройтолд нөлөөлж буй зэргийг тодорхойлно.

3. Албан лицензтэй үр үржүүлгийн тогтолцоонд үрийн чанарын хяналтыг бий болгох, нэвтрүүлэх, чанарын хяналтын ялгаатай системийг бий болгох, эдгээрийг мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр судалж эзэмших. Баталгаажуулалт нь эдгээрийн зөвхөн нэг нь бөгөөд хөгжиж буй орнуудад төдийлөн хийгддэггүй; стандартыг төслийн өмнөх туршлага дээр үндэслэн дахин хянаж үзэх хэрэгтэй. (үйл ажиллагаа 1.2.2)

4. Монгол орны баруун, өмнөд, зүүн бүс нутгийн элит үр үйлдвэрлэлийг үнэлж, бүсийн ялгавартай стратеги боловсруулна

Судалгааны өртөг, клоны сонголтын селекцийн практик, бэсрэг булцууны юмуу супер-супер-элит үрийн энгийн тээвэрлэлт

5. Үрийн ангилал тус бүрийн үйлдвэрлэлийн өртгийг тодорхойлно

Өртөгийн тооцоо хийж, тохиромжтой үнэ тогтоосноор хэрэглээний явцад үрийн төмсийг хүнсэнд ашиглагдахаас сэргийлэхээс гадна, эдийн засгийн чадавхиар ялгаатай үйлдвэрлэгчдийн дунд тэгш харилцан уялдаа бий болгож, үрийн бизнесийг хөгжүүлнэ

6. Монголын нөхцөлд үр үйлдвэрлэл, чанарын хяналт, баталгаажуулалт явуулах, нүдэн баримжаагаар өвчнийг илрүүлэхэд өөр өөр вирусын шинж тэмдгийн илрэлийг олж мэдэх нь чухал юм. Холбогдох мэргэжилтнүүд нь жил бүр мэдлэг, чадвараа дээшлүүлэх боломжоор хангагдах ёстой

7. Төрийн болон хувийн секторын оролцоотой хамтарсан үр үйлдвэрлэлийн нэгж байгуулах боломжийг судлах,

Үр үйлдвэрлэгч төрийн байгууллагууд өөрөө өөрийгөө санхүүжүүлэх боломжийг судалж үзэх, гарсан үр дүнгээс хамаарч туршилтын нэгжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

8. Албан лицензтэй үр үйлдвэрлэлд зориулж усалгааны нөхцөл, тоног төхөөрөмжийн (худаг гаргах) боломжийг судлах, үүний дагуу сайжруулалт хийх. Цөөн тооны зарим албан үр үржүүлэгчид нь усны найдвартай эх үүсвэргүй байгаа нь үнэтэй, дээд үржүүлгийн материалын ургацыг алдахад хүргэж болно. Тиймээс төсөл нь боломжийн үнээр худаг гаргах боломжийг судалж, асуудлыг шийдвэрлэх бусад шийдлийг олно. (өмнө нь усалгаатай байсан талбайд тариалах)

9. Албан үр үржүүлэгчдийн чадавхийг бэхжүүлэх

Талбайд нь очиж зөвлөгөө өгөх, туршлага судлах аялалд оролцуулах зэргээр Албан үр үржүүлэгчдийн чадавхийг бэхжүүлнэ.

### **1.3 Албан бус үр үржүүлэгчид нь цаашдаа хэрэгцээн дээр үндэслэсэн хэмжээгээр, тогтвортой байдлаар чанартай үр үйлдэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлнэ**

1. Өөр өөр агро-экологийн нөхцөл дэх үрийн доройтлын явцыг судална.

Доройтлын судалгааг аль болох түргэн хугацаанд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран хийж эхлэх ба газар тариалангийн төвийн бүсэд 2-3 сортыг хамруулна: судалгааны талбайд доройтлын динамикийг тодорхойлох ба доройтолд нөлөөлөх бусад хүчин зүйл, тариалах технологи зэргийг харгалзана

2. Чанарын дэмжлэг, чанарын хяналтын ялгаатай стратегиудыг үнэлэх

Албан бус үр үржүүлэгчдийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах гэсэн чармайлтыг дэмжинэ; Чанарын хяналтын ялгаатай системүүдийг үнэлж, Монголын нөхцөлд тохирохыг сонгоно. Баталгаажуулах нь чанарын хяналтанд багтах боловч хөгжиж буй орнуудын хувьд төдийлөн сайн хөгжөөгүй; ТООТ нь энэ асуудлаар гадаадын зөвлөх үйлчилгээ үзүүлнэ; хамгийн ирээдүйтэй сонголтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

3. Үр үржүүлгийн Best-Bet технологийг нэвтрүүлж, мониторинг хийх

Үйлдвэрлэлийн эргэлзээтэй асуудлыг шууд үржүүлгийн талбайд энгийн туршилтаар шийдвэрлэх; сонирхол татсан фермерүүдийн дадлага туршлагыг судлаж баримтжуулах; Best-Bet технологгоор товхимол гаргах, эдгээр практик туршлагаудад мониторинг хийх

4. Албан бус үр үржүүлэгчдийг тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба үр үржүүлгийн албан салбар, ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгч нартайгаа хамтран ажиллах чиглэлд нь үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ.

Үйлдвэрлэгчдэд зөвлөгөө өгч, сүлжээ байгуулах, сайн чанарын үр үйлдвэрлэгчийн нэр хүнд олж авахад нь дэмжлэг үзүүлнэ

5. Албан бус үр үржүүлэгчдийг сургалтанд хамруулна

Ялангуяа шинээр сонгогдох үр үржүүлэгчдэд сургалт зайлшгүй шаардлагатай

6. Албан бус үр үржүүлэгчдийн зоорины хадгалалтын нөхцлийг сайжруулна

Ялангуяа шинэ үр үржүүлэгчдийн хувьд зоорины хадгалалтын нөхцлөө сайжруулах зайлшгүй шаардлагатай.

7. Төмс хадгалах явцад тохиолдож буй хүндрэл бэрхшээлийг судалж, үр үржүүлэгчдийн хамт шийдвэрлэх арга замыг олно

Үрийн хадгалалтын явцад тохиолддог бэрхшээлд чийг, температурын тохиромжгүй байдал орох бөгөөд үүнд мониторинг хийж, өртөг багатай, энгийн аргуудыг олж илрүүлэн, нэвтрүүлнэ.

8. Тодорхой бүс нутаг дахь албан бус үр үржүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх бөгөөд үүний зорилго нь анхдагч ба хоёрдогч үр үржүүлэгчдийн орон нутгийн, тогтвортой сүлжээг бий болгоно.

9. Хярууны (бусад байгалийн гамшиг) талаар эрт урьдчилан мэдээлэх тогтолцоог бий болгож, турших. Ургалтын үеийн хярууны тухай урьдчилан

сэргийлэх систем бий болгох нь харьцангуй хялбар энгийн бөгөөд гар утасны сэрүүлэг дээр үндэслэн хийж болох юм.

10. Албан бус үр үржүүлэгчдийн усалгааны тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг үргэлжүүлж, боломжтой газруудад бороожуулагч төхөөрөмжөөр хангана.

11. Орон нутгаасаа олох боломжгүй учраас төсөл нь хөдөө орон нутгийн үр үржүүлэгчдийг шаардлагатай пестицид, бордоогоор хангана.

12. Ханган нийлүүлэлтийн арилжааны системийг олж тогтоон бий болгоно. Ингэснээр төсөл нь цаашид жижиглэнгийн хор, бордоогоор хангах үүрэг гүйцэтгэх шаардлагагүй болно.

#### **1.4 Жижиг фермерүүдийг чанартай үрээр хангах механизм бий болгох, тэд үрийг хэрхэн үр ашигтай хэрэглэх стратегийг түншүүдийн хамт олж илрүүлэх**

1.1.3.4-д холбогдох үйл ажиллагаа нь төслийн оролцоогүйгээр хэрхэн явагдахыг олж тогтоохын тулд албан бус үр үржүүлэгчдийн бусад жижиг фермерүүдэд нийлүүлэх чанартай үрийн эргэлтийг судална.

2. Үрийн орон нутгийн эргэлтийг дэмжих

Шинэ сортуудын үрийн зарим төрлийн эргэлтийн санг орон нутгийн түвшинд бий болгох, гэхдээ 1.4.1 дээр үндэслэн “чанартай үр” гэсэн нэр хүндийг унагахгүй байхад анхаарах ёстой.

3. Жижиг фермерүүдийн одоо хэрэглэж буй үрэнд үрийн өвчний халдварын түвшин, ургацанд нөлөөлөх байдлыг судлах

Энэ нь жижиг фермерүүдийг “хуучин” үрийн талаарх мэдээллээр хангах бөгөөд; фермер дэх энгийн туршилтуудыг ашиглан шинэ сортын үрийн эдийн засгийн дүн шинжилгээний үндэс болох ургацын давуу талыг тодорхойлно.

4. 0.1га-гаас бага талбайд төмс тариалдаг жижиг фермерүүдийг үрээр хангах тохиромжтой түншүүдийг илрүүлж олох бөгөөд эдгээр түншүүд нь орон нутгийн ТББ-ууд, экстейншний төвүүд байж болно.

5. Эдгээр түншүүдтэй хамтран жижиг фермерүүдийг үрээр хангах ялгаатай стратегиудыг боловсруулна.

Зорилтот фермерүүдийн ашиг орлого олох, хүйсээр ялгаварлагдахгүй байх, дүгнэлт гаргах зэрэг стратегийг үнэлэх

6. Түншүүдийн хамт үр дүнг боловсруулж, олон нийтэд сурталчлах бөгөөд үүний зорилго нь бусад байгууллагууд (ТББ-иуд г.м)-д хэрэглэгдэх ирээдүйтэй стратегийг боловсруулах асуудал юм.

7. Жижиг үйлдвэрлэгчдэд зориулж үрийн хэрэглээ, үрийн шинэчлэл, сортын тариалалт зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулна.

8. Албан ба албан бус үр үржүүлэгчид, ТББ-ууд, жижиг фермерүүдийн хооронд шаардлагатай уялдаа холбоог бий болгох бөгөөд энэ нь төслийн хамтын ажиллагааг тогтвортой, бие даасан болгоход чиглэгдэнэ.

### **1.5 Монголын нөхцөлд тохиромжтой шинэ сортуудыг сонгон шалгаруулах, тэдгээр сортын үрийг үржүүлэх ажлыг эхлүүлнэ**

1. Сорт сорилтыг үргэлжлүүлнэ.
  2. Хятад болон бусад эх үүсвэрийг ашиглан селекцийн эх материалыг олшруулах өргөн хэмжээний генотипийг туршин судалж, сонгох
  3. Оролцооны аргаар фермерүүдийн оролцоотойгоор шинэ генотипийг үнэлнэ.
  4. Ирээдүйтэй сортуудын албан үр үйлдвэрлэлийн тохиромжтой хэлбэрийг аль болох хурдан бий болгож, хэрэгжүүлэх
- Сортыг батлагдахаас өмнө үр үржүүлгийг эхлүүлэх нь уг сорт батлагдаж жагсаалтанд бичигдэхгүй тохиолдолд эрсдлийг үүсгэж болох бөгөөд анхдагч судалгааг үнэн бодитой явуулж, генотипийг оновчтой илрүүлснээр ийм эрсдэл гарахгүй.
5. Сорт сорилт, сонголтын одоо мөрдөж буй арга зүй, дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг оролцогч талуудын хамт боловсруулж, төсөл дууссаны дараа төслийн үр дүнд тулгуурлан боловсруулж, шийдвэрлүүлэх

### **Үр дүн 2. Үйлдвэрлэлийн арга технологийг сайжруулах**

Энэ үр дүн нь жижиг үйлдвэрлэгчдэд голлон чиглэнэ. Сайжруулах боломжийг 1.4 дэх үр дүнд тодорхойлон гаргасан байгаа. Төсөл нь хөдөө орон нутагт фермерүүдтэй ойр байдаг түншүүдтэй нягт хамтран ажиллана (ТББ, бусад). Төсөл нь эхний үе шатандаа бага хэмжээний талбайд тариалагчдаас албан бус үр үржүүлэгчдийг сонгон хамтран ажилласан. Эдгээрийн олонх нь агрономич мэргэжилтэй учраас 1990-ээд оноос өмнө мөрдөж байсан технологийн талаар мэдлэгтэй, түүндээ тулгуурлан төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, зарим тохиолдолд технологи сайжруулах тал дээр төсөлд туслалцаа үзүүлэх боломжтой байгаа юм. Жижиг фермерүүдийн оршин сууж, амьдарч, үйл ажиллагаагаа явуулж буй орчин нь экологийн хувьд, эдийн засгийн хувьд ч, агро-экологийн хувьд ч, боломж нөхцлийн хувьд ч хоорондоо эрс тэс ялгаатай, байдаг учир тэдгээртэй хамтран ажилласнаар өөр хоорондоо ялгаатай маш олон төрлийн дэмжлэг үзүүлэх, технологийн янз бүрийн хувилбаруудыг хөгжүүлэх, харилцан суралцах боломж гардаг. Тэдэнтэй хамтран шинэ арга технологи боловсруулах явцад тухайн тодорхой орчны онцлогийг тусгасан шинэ сэдэл, санаа олноор гарч энэ нь тухайн орон нутгийн хөрсөн дээр хийгдсэн учир орон нутгийн удирдлагын бодлого болж дэлгэрэх, хэрэгжих бололцоо бүрэн байдаг, орон нутгийн бодлогод лоббидон тусгуулах боломж ч өргөн юм. Энэ ажиллагааг оролцооны аргад тулгуурлан явуулах бөгөөд орон нутагт амьдардаг, фермерүүдтэй ойр дотно түншүүдийн хамтын ажиллагаа, туслалцааг өргөн ашиглана. Оролцогчдын идэвхийг сэргээх, тэдний санаа бодлыг тусгах, түншийг сонгох, зорилгоор “саналын хуудас” аялуулж, дүгнэж тайлагнаж байх зарчмыг баримтална.

## **2.1.Оролцооны аргыг ашиглан зорилтот бүлгүүдийн онцлогт тохирсон төмсний үйлдвэрлэлийн үр ашигтай, тогтвортой арга технологийг боловсруулах, хөгжүүлэх**

1. ХУН болон түншүүд хамтран технологи хөгжүүлэх талаар оролцооны аргад тулгуурласан сургалтууд зохион байгуулах
2. Төмсний салбарын одоогийн байдалд дүн шинжилгээ хийх, чиг хандлагыг тодорхойлох, зорилтот бүлгүүдийг тодорхойлох (ядуу хэсэг, хүнсний харилцаа г.м). Ялангуяа шинээр тодорхойлогдож бүртгэгдэж буй зорилтот бүлгүүдэд анхаарал хандуулах
3. Сонгогдсон зорилтот бүлгүүдийн төмс үйлдвэрлэлийн технологийн системийг судлах  
Шинээр эхэлж буй зорилтот бүлгүүд, жижиг үйлдвэрлэгчид, малчид, малчин байсан хүмүүс
4. Хүйсийн харьцааны асуудлаар газар дээр нь сургалт зохион байгуулах, судлаачдыг оролцуулах, хүйсийн тэгш байдал энд чухал ач холбогдолтой бөгөөд нийгэм судлаачдыг судалгаанд татан оролцуулснаар төслийн ажилтнууд болон түншүүдэд хүйсийн тэгш байдлын асуудлаар тодорхой мэдлэг олгоно.
5. Оролцооны судалгааны үр дүнд зорилтот фермерүүдтэй хамтран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, тогтворжуулах боломжийг тодорхойлж, оновчтой арга технологийг боловсруулна.
6. Бууц болон бусад органик бордоог төмсний тариаланд ашиглах байдалд үнэлгээ өгч, органик бордоо хэрэглэх, оновчтой арга технологийг сурталчлан дэлгэрүүлнэ.
7. Төмсний үйлдвэрлэлийн экологид ээлтэй технологид үнэлгээ өгч, түүнийг нэвтрүүлэх оновчтой арга замыг сонгоно. Бусад орнуудын туршлагыг судлах асуудал чухал.
8. Жижиг, дунд фермерүүдэд тохиромжтой шинэ төрлийн бордоо, химийн бодисыг туршиж нэвтрүүлэх, хэрэглэх зөвлөмж боловсруулахад УХЭШХ-тэй хамтран дэмжлэг үзүүлнэ.
9. Урт хугацааны зээлийн бүтээгдэхүүний талаар төр засгийн түвшинд санал боловсруулж, газар тариаланд зориулсан тусгай зориулалтын зээлийн бүтээгдэхүүний талаар Засгийн газраас арилжааны банкуудтай зөвшилцөл хийх ба энэ нь фермерүүдэд банкуудаас итгэл үзүүлэхэд тустай.
10. Жижиг болон дунд хэмжээний үйлдвэрлэл явуулахад тохиромжтой бага оврын техник, багаж төхөөрөмжийг судалж, сонголт хийж, талбайн үзүүлэнгээр сурталчлах

## **2.2.Экологид ээлтэй технологийг өргөн нэвтрүүлэх**

1. Технологиудын эдийн засаг, байгаль орчин, нийгмийн ач холбогдлыг харьцуулан судалж, экологид ээлтэй эдийн засгийн хувьд үр ашигтайг нь сонгон нэвтрүүлэх, дэлгэрүүлэх
2. Зорилтот бүлэг тус бүрд тохиромжтой, хүртээмжтэй үр дүн, арга туршлагыг бий болгох  
Үзүүлэх хуудас, мэдээллийн хэрэгсэл, экстейншний материал зэрэгийг ашиглах, тодорхой фермерүүдэд ойр дөт байдлаар оролцогчдын баг бүрдүүлэх

3. Фермерүүдэд тараах сургалтын материалыг боловсруулах, ашиг тустай болон ашиггүй байдлын явцад үнэлгээ хийх
- Оролцогчидтой ойр фермерүүдтэй хамтарна.
  - Материалын чанар, агуулгыг явцын дүнд байнга сайжруулна.

### **Үр дүн 3. Борлуулалтын сүлжээг сайжруулах**

Төсөлд шинээр сууж буй үр дүн болно. Иймээс энэ чиглэлийн үйл ажиллагаануудыг урьдчилсан байдлаар суулгаж өгсөн. Эдийн засгийн мэргэжилтний тусламжтайгаар энэ хэсэгт тодотгож, төлөвлөгөөндөө тусгах боломжтой.

#### **3.1. Хот, хөдөөгийн хүн амын хүнсний бүтцэд төмс, төмсний бүтээгдэхүүний гүйцэтгэж буй үүрэг, цаашдын чиг хандлагыг тодорхойлох**

1. Хүн амын янз бүрийн давхаргын төмсний хэрэглээ, хүнсний бүтцэд нь төмсний гүйцэтгэж буй үүргийг судлан, дүгнэлт гаргах  
Хотын хүн ам, малчид, малчин байсан хүмүүс, өрхийн цэцэрлэг эрхлэгчид, тариалангийн компаний ажиллагсад, тариалан эрхлэгчид, фермерүүд зэрэг хөдөөгийн хүн амын янз бүрийн ангиллуудын төмсний хэрэглээг ялгавартай гаргаж, боловсруулна. Хэрэглээг тооцоолохдоо улирлын байдал, хэрэглээнд учрах бэрхшээл (хүрэлцээ, хүртээмж, хадгалалтын үнэ ханш зэрэг) бэлтгэлийн гол аргууд, хэрэглэгчдийг урьдчилан бэлтгэх, хоол тэжээлийн үндсэн эрсдэл
2. Төмсний хэрэгцээг ихэсгэх боломжийг судлах  
Хотын хүн амын хүнс тэжээлийн эрсдлийг бууруулах гол арга нь төмсний хэрэглээг нэмэгдүүлэх, хүүхдийн хоол тэжээлийн дутагдлаас сэргийлэхэд үнэ хямд, чанар сайтай бүтээгдэхүүн болох төмсний гүйцэтгэх үүрэг, ач холбогдол их

#### **3.2. Хангамж худалдааны сүлжээний судалгаа, түүнийг сайжруулах арга замыг оролцогч, хэрэглэгч нарын оролцоотойгоор хийх**

1. Төмсний худалдааг сайжруулах жижиг төслүүдийг дэлгүүрүүдэд зохион байгуулж эхлүүлэх. Ялангуяа шинэ сортын сав баглаа боодол, тээвэрлэлт, овор хэмжээнд анхаарал тавих
2. Боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх замаар бүтээгдэхүүний үнэ ханшийг дээшлүүлэх шинэ боломжийг судлах
3. Сортын болон бүтээгдэхүүний чанарын үнэлгээг худалдааны сүлжээн дэх оролцогчдын тусламж оролцоотойгоор гүйцэтгэх
4. Шинэ төмсний борлуулалтын сүлжээнд үнэлгээ дүгнэлт өгөх, хөдөөгийн зорилтот зах зээл, борлуулалт
5. Танилцуулга, сурталчилгаа, шошгоны үнэлгээ, судалгаа. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цэг дээр байгуулсан “Жинхэнэ Монгол төмс” хаяг, тодорхойлолт, сортын тодорхойлолтын онцлох үзүүлэлтүүдийг нарийвчлан судалж баталгаажуулах
6. Үнэ ханшны өсөлтийн зэрэгцээгээр төмсний хураалтын дараах ажиллагааны менежментийг сайжруулах, төмс хадгалалт, тээвэрлэлтэнд учирч буй бэрхшээл

7. Эрүүл мэндтэй хамаарах төмсний чанарын сурталчилгаанд хэрэглэгчдийн анхаарлыг хандуулах Хүмүүсийн эрүүл мэндэд тавих анхаарал, санаачлага нэмэгдэж байгааг ашиглах, энэ чиглэлийн сурталчилгаанд оролцох, нэрэмжит ажил, чиглэсэн сурталчилгаа хийх (Жишээ нь “ОУ-ын төмсний жил” г.м)

#### **Үр дүн 4. Бодлогын зохистой орчин, нөхцөл**

Зохицуулах хороог өргөтгөж, үйл ажиллагааг идэвхжүүлэх, оролцогчдын бүх төлөөллөөс оролцуулах

4.1. Зохицуулах хороог хүчирхэгжүүлж, төмсний үндэсний хороо болгон зохион байгуулах

4.2. Хорооны үүрэг, түүний биелэлтийг хянах, төмсний секторын үйл ажиллагааг зохицуулах, хүчирхэг бүтцийг бий болгох

4.3. Төмс үйлдвэрлэгчдийн үр ашгийн үнэлгээг хийн, туршилтын үр дүнд үндэслэн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах. Үр ашиг нь хангалтгүй байгаа нь илэрсэн тохиолдолд туршлага судалгаа болон бусад үйл ажиллагаа ил үр дүн дээр тулгуурлан түүнийг сайжруулах бодлого боловсруулна.

4.4. Зохицуулах хорооны бүх гишүүдийн шууд ба шууд бус оролцоог идэвхижүүлнэ. Зохицуулах хорооны бүтэц, бүрэлдэхүүнийг эргэж авч үзэх магадлалтай.

#### **2.6. Стратегийн зарчмууд**

Төсөл нь тавьсан зорилгодоо хүрэхийн тулд стратегийн болон үйл ажиллагааны дор дурьдсан зарчмуудыг баримтална.

**Оролцооны арга.** Төлөвлөлт, хэрэгжүүлэлт, явцын хяналт үнэлгээний бүх арга хэмжээ нь оролцооны арга дээр тулгуурлана. Төмс тариалагч аж ахуйн нэгж болон өрхийн үйлдвэрлэгчдийг өргөн оролцуулснаар тэдний эрх ашиг, өмчлөлд халдахгүй, харин тэдний санал бодол, саад бэрхшээлүүдийг нарийн сайн судалж, шийдвэрлэх ач холбогдолтой. Хөтөлбөр нь янз бүрийн түвшний үйлдвэрлэгчид, экологи газар зүйн өөр өөр орчин, үйлдвэрлэлийн өөр өөр чиглэл болон зорилго бүхий өргөн массыг хамран ажиллахаар төлөвлөж байна. Төрийн бодлого боловсруулагчдаас үйлдвэрлэгчид, үрийн болон товарын төмсний худалдаа, бизнес эрхлэгчдийг бүхэлд нь хамарсан, үрийн аж ахуй, үр хангалтын тогтвортой системийг бий болгож, төмсний аж ахуйн эдийн засгийн үр ашгийг сайжруулахад тус төслөөс тодорхой дэмжлэг үзүүлэх юм.

**Тэгш байдал.** Хөтөлбөр нь одоогийн оршиж буй нийгмийн болон эдийн засгийн тэгш бус байдлыг багасгахад чиглэгдэж байна. Энэ нь хүйсийн ялгавартай хандлага, үндэс угсаагаар ялгаварлах үзэл зэргийн эсрэг байгаа бөгөөд цаашид энэ чиглэлээр тогтвортой, тэнцвэртэй бодлого баримтална. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацааны туршид тэгш байдлыг байнга хянаж байх болно. Газар, ус зэрэг нийтийн хэрэглээний нөөцтэй нягт холбоотой учир хөтөлбөр нь энэ талаар онцгой анхаарал тавьж, ядуу болон эмзэг бүлгийнхэнд байгалийн нөөц ашиглахад тэгш эрхтэйгээр оролцох боломж олгоно. Эмзэг бүлгийнхний хэрэгцээ болон боломжийн талаар хөтөлбөрөөс зориуд анхаарч,

байгаа нөөц бололцоог ашиглах талаар тусгайлан мэдээлэлээр үйлчилнэ. Эмзэг бүлгийн айл өрхийн амьжиргаанд гарсан өөрчлөлт, үр дүнгийн үр ашигт төсөл мониторинг хийнэ.

**Шинэчлэл.** Хөтөлбөрийн хүрээнд төмсний аж ахуйн салбарт гарч байгаа шинэ дэвшилтэт технологи, техник болон орчин үед өргөнөөр ашиглагдаж байгаа дэвшилтэт үзэл санааг Монгол улсын төмсний аж ахуйн салбарт нэвтрүүлэх, сурталчлах, технологи дамжуулан нутагшуулах ажил хийгдэнэ. Энэ нь үндэсний болон олон улсын хэмжээнд хэрэглэгдэж байгаа тэргүүний туршлага, арга ажиллагааг сурталчлах, нэвтрүүлэх ажил юм. Өөрөөр хэлбэл, шинэ шилдэг сортуудыг олж ирж нутагшуулах, төмс үйлдвэрлэл, хадгалалтын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг ажлууд энд хамаарна. Ялангуяа экологийн цэвэр төмсний үйлдвэрлэлд анхаарал хандуулах бөгөөд энэ чанараараа гадаадын төмсний бүтээгдэхүүнтэй өрсөлдөх, Монгол орны эмзэг экологийг хамгаалж, экологийн аюулгүй үйлдвэрлэл хөгжүүлэх хэмжээнд хүрнэ. Иймээс хөтөлбөрийн энэ шатанд шинэ технологийг газар дээр нь туршин нэвтрүүлэх, системтэйгээр албажуулж, нийтийн хүртээл болгоход гол анхаарлаа чиглүүлнэ.

**Эрх мэдэл олгох.** Хөтөлбөр нь албан ба албан бус төмсний үр үйлдвэрлэгчид, хяналтын байгууллагын хүчин чадлыг бэхжүүлэхэд чиглэгдэнэ. Ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн өрхүүдэд сайн чанарын үр олгож, технологийг нь сайжруулснаар тэдний чадавхи, амжиргааг дээшлүүлэхэд анхаарна. ТТҮЗ гэдэг төрийн бус байгууллага байгуулснаар төмс үйлдвэрлэгчдийн дуу хоолойг олон нийтэд болон төр засагт хүргэх, тэдний эрх ашгийг хамгаалах, шинэ санаа, техник, технологийг орон нутагт сурталчлах, нэвтрүүлэх, орон нутгийн мэргэжилтнийг сургах ажил хийгдэнэ.

**Тогтвортой байдал.** Төмсний үрийн чанарыг сайжруулах асуудлыг авч үзэхдээ эдийн засаг, экологи, нийгмийн бүх талын асуудлыг хамтад нь авч, үр ашигтай үйлдвэрлэлийн зарчмыг баримтална. Төр засгийн удирдлага болон олон нийтийн холбоог бэхжүүлж, төмсний баталгаатай үр үйлдвэрлэхэд адил тэгш хариуцлага, үүрэг хүлээдэг болгоход анхаарна. Албан ба албан бус төмсний үр үйлдвэрлэл нь бүхэлдээ экологийн зарчимд тулгуурлана. Органик тариаланд тусгайлан анхаарна. Химийн бодисыг хэрэглэхдээ онцгой анхааралтай, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд аюулгүй байдлаар ашиглах, хэрэглэх зааврыг чанд мөрдөнө.

**Мэдлэг түгээлт, мэргэжлийн мэдлэг ахиулалт.** Хөтөлбөрийн явцад хөдөөгийн хүн амын дунд төмсний аж ахуй хөтлөн явуулах мэдлэг мэргэжил эзэмшихэд тусална. Жижиг үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалтыг хүргэнэ. Гадаад, дотоодын тэргүүний үйлдвэрлэгчдийн туршлага, дадлагыг бусдад түгээх, Монгол орны тодорхой бүс нутгуудад үйлдвэрлэл явуулах, үр үржүүлэх мэдлэг, дадлагыг үйлдвэрлэгчдэд олгоно. Хөтөлбөрийн хүрээнд Монголын үндэсний болон дэлхийн шилдэг технологиудыг сургах, төмсний үр болон товарын үйлдвэрлэлийн тэргүүний туршлага, шинэлэг ололтуудтай тухай бүр нь танилцуулж, талбайн сургалт, үзүүлэх сургууль, болон бусад арга хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлж, сургаж байх болно.

**Зардал хуваах зарчим.** ШХХАА нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцдаа төрийн байгууллагууд, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах бөгөөд аль ч хэлбэрийн өмчийн байгууллагатай хамтран ажиллана. Гагцхүү тэд хөтөлбөрийн үйл ажиллагаанд гарах зардлыг хуваан гаргах сонирхолтой байх ёстой. Хамтран ажиллаж байгаа бүх хамтрагчид, бусад хүмүүсийн ажлын тухай мэдээллийг өргөн олон түмэнд байнга сурталчилж байх болно.

**Хөрвөх чадвар буюу төслийн уян хатан чанар.** Хөтөлбөр нь янз бүрийн хэмжээ, үйл ажиллагаа бүхий төмс үйлдвэрлэгчид, экологийн харилцан адилгүй нөхцөлд үйлдвэрлэл явуулах онцлог, тэдний давуу болон дутагдалтай талыг тусгахыг хичээсэн. Орон нутгийн удирдлага, төмс үйлдвэрлэгчдийн санал, зөвлөгөөнийг бүрэн тусгасан. Төмс тариалж аж амьдралаа дээшлүүлэхийг хүсэж байгаа дундаас доош амьдралтай олон хүн, аж ахуйн нэгж төслийн бэлтгэл шатанд хамрагдаж, санал бодлоо хэлсэн байгаа. Энэ нь хөтөлбөрийн стратегийг боловсруулах гол үндэс болсон гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд нэгэнт олон түмний дэмжлэг хүлээсэн учир цаашид хэрэгжих бүрэн үндэстэй гэж үзэж байна.

**Хамтын ажиллагаа.** Монгол Улсын төр засгаас энэ төслийг дэмжиж байгаа бөгөөд ХХААЯ өөрийнхөө бүтцэд хөтөлбөрийн Зохицуулах Хороог байгуулан ажиллуулж, салбарын зохицуулалтанд голлох үүрэгтэй оролцож байна.

## 2.7 Хэрэгжүүлэх зарчмууд

**Хөтөлбөрт оролцогч талуудын хүчин чадал, чадавхийг сайжруулах:** Төслийн үндсэн зарчим болох төлөвлөгдсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд үндсэн оролцогч талуудын хүчин чадал, чадавхийг хөгжүүлэх нь хэвээр хадгалагдах болно. ХУН нь өөрөө хэрэгжүүлэх үйл ажиллагааг идэвхижүүлэгч, эрчимжүүлэгчийн үүргийг гүйцэтгэх болно. ХУН нь бие даан бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүчин чадал байхгүйгээс гадна цаашид хөтөлбөр хэрэгжих хугацаанаас хэтэрсэн үйлчилгээг үзүүлэхээс татгалзах хэрэгтэй. Тухайлбал:

**Дасан зохицуулах судалгааны ажил хийх:** Хөтөлбөр нь бүхэлдээ төмсний салбарын дасан зохицуулах, фермерүүдийг оролцуулсан судалгааны ажлыг гүйцэтгэх чадавхийг бэхжүүлэх болно. Төмсний үйлдвэрлэл нь нарийн төрөлжин хөгжиж байгаатай холбоотойгоор төрөл бүрийн зорилтот бүлгүүдийн хэрэгцээг нарийвчилсан бус, тойм зөвлөмжүүд нь хангахаа больж байна. Ер нь ирээдүйд үйлдвэрлэлд туршигдаагүй, гарын авлагын дагуу фермерийн аж ахуйг эрхлэхээс илүү нарийн зүйл шаардлагатай болно. 1990-ээд оноос өмнө хэрэглэгдэж байсан болон сүүлийн үед бусад гадны улс орны нэвтрүүлж буй технологиуд нь өөр өөр оролцогч талуудыг хамран талбайд нарийвчлан үнэлэгдэх шаардлага гарч байна. Иймээс дасан зохицуулах судалгааны ажлыг улам бүр хөгжүүлэх хэрэгтэй.

**Хамтран ажиллагч талуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцуулах:** Хөтөлбөрийн 2 дахь үе шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдөөд байгаа дасан зохицуулах судалгааны ажлуудыг нь хамтрагч талуудад, тухайлбал орон

нутагт үйл ажиллагаагаа явуулж буй, тодорхой зорилтот бүлгүүд болох гол төлөв жижиг фермерүүдтэй тогтвортой харилцаа холбоотой ажилладаг ТББ-уудад хариуцуулан хийх болно. Энд шинэ хамтран ажиллагчийг тодорхойлж, тодорхой хийгдэх үйл ажиллагаа, судалгааны ажлын зорилго, үр дүн, арга зүйгээ хэлэлцэн, хүлээн зөвшөөрсөний үндсэн дээр ТББ болон хөтөлбөр хооронд гэрээ байгуулах замаар явагдана. Хийгдэх ажил бүр дээр хөтөлбөр ТББ хоёр хамтран ажлын удирдамжийг боловсруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг нь болох болно.

**Оролцооны аргад үндэслэсэн судалгааны ажлыг хийхэд суралцах:** Хөтөлбөр нь өнөөг хүртэл хамтран ажиллаж байсан фермерүүдтэй харьцуулахад нилээд ялгаатай байх жижиг тэр дундаа өрхийн үйлдвэрлэгчид рүү хандан ажиллахаар болж байгаатай холбоотойгоор тэдгээрийн хэтийн төлөв байдал, чадамж бололцоо, саад хязгаарлагч хүчин зүйлүүдийг судлан, сайжруулах нь чухал болно. Мөн шинээр сонгогдох фермерүүдийг сонгон судлахад цаг алдалгүй, дасан зохицуулах судалгааны ажилд шууд татан оролцуулах нь үр дүнтэй болох болов уу. Хөтөлбөр нь оролцооны аргад үндэслэсэн судалгааны ажил хийх талаар сургалтыг дээрхи ажлыг гүйцэтгэх хамтран ажиллагч болон зарчмыг нь ойлгуулах зорилгоор ажилтанууддаа зориулан явуулах шаардлагатай. Энэхүү сургалтыг фермерүүдтэй харьцах харилцаагаа дадлагажуулах зорилгоор энэ чиглэлийн ажил хийгдэж байгаа аль нэгэн хамтран ажиллагчийн талбайд явуулах нь зөв.

**Жендерийн асуудлыг анхаарах:** Жендерийн асуудлыг жижиг фермерүүдтэй ажиллаж эхлэхэд улам бүр чухалчлан үзэх шаардлагатай болно. Хөтөлбөр нь жендерийн асуудлыг өөрийнхөө бүхий л үйл ажиллагаанд тусган ажиллахаар зорих болно. Оролцооны аргад үндэслэсэн судалгааны ажил хийж буй хамтран ажиллагч талууд мөн жендерийн асуудлыг анхааралдаа авч, судалгааны ажлыг илүү үр дүнтэй, гарсан үр дүн нь жендерийн тэнцвэрт байдалд нөлөөлөхүйц байна. Хөтөлбөр нь энэ чиглэлийн сургалтыг, техникийн зөвлөгөөг хамтран ажиллагч нартаа мөн ХУН-ийн ажилтанууддаа зориулан зохион байгуулах болно. Ялангуяа, сургалтыг ажилтай нь уялдуулан, дасан зохицуулах судалгааны ажлын хүрээнд явуулах нь зүйтэй.

**Хөтөлбөрийн баримт бичгийн бүрдүүлэлтийг сайжруулах:** ХУН-ийн дасан зохицуулах судалгааны мөн үзүүлэнгийн талбарын ажил, туршлага судлах аялалын ажлын тайлан боловсруулах, түүнд дүн шинжилгээ хийх чадварыг сайжруулна. Ялангуяа, хөтөлбөрийн үзүүлэнгийн талбарын ажлын үр дүнг баримтжуулсан байдал нь Дунд шатны үнэлгээний багийн шүүмжлэлд өртсөн. Тухайлбал, хамтран ажиллагч талуудад хариуцуулсан судалгааны ажлын тайлан, баримт бичгийг хянах, сайжруулах тал дээр зөвөлгөө өгөхийн тулд ХУН-ийн ажилтанууд нь өөрсдөө баримт бичиг боловсруулах, үр ашигтай тайлан бүрдүүлэх чадвартай байх ёстой.

**Техникийн зөвлөмж, зөвлөгөө авах:** Хөтөлбөр нь Олон улсын төмсний төвтэй /ОУТТ/ сайн харьцаа тогтоосон бөгөөд 2 дахь шатанд улам бүр сайжруулан ажиллах болно. ОУТТ нь төмсний үйлдвэрлэлийн бараг бүх салбарт асар их туршлага хуримтлуулсан байгууллагын хувьд хөтөлбөрт төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай удмын материал болон бусад зүйлсийг нийлүүлэх боломжтой. Үүнээс гадна оролцооны аргад үндсэлсэн судалгааны ажил хийх, борлуулалтын сүлжээг сайжруулах, хот суурин орчмын газар тариаланг хөгжүүлэх /сумын төв дэх жижиг үйлдвэрлэгчидтэй холбоотойгоор/ чиглэлийн сургалт, техникийн зөвлөгөөг өгч болно.

**Хөрш зэргэлдээ улс орнуудтай холбоо харилцаагаа бэхжүүлэх:** Хөтөлбөр хөрш орнууд, ялангуяа Хятад улстай байгуулсан харилцаа холбоогоо улам хөгжүүлэх болно. Мэдлэг, мэдээлэлээ үргэлжлэн солилцохоос гадна удмын материал илүү их хэмжээгээр хүлээн авах болно.

**Хөнгөлөлтийн хэмжээг багасгах:** Хөтөлбөр нь эхний үе шатандаа үр үржүүлэгч нарт хөнгөлөлттэй зээллэгийн хэлбэрээр тоног төхөөрөмж бусад зүйлсийг олгосон байна. Зоорь, тоног төхөөрөмжийн өртгийн 50%-ийг хөтөлбөрөөс төлж байсан бол үрийн зээллэгийн хувьд албан бус үр үржүүлэгчид нь үр хэлбэрээр 200% буцаан төлж байсан бол албан үр үржүүлэгчид нь хэдий хэмжээний элит үр үйлдвэрлэн ямар хэмжээний үр буцаан төлбөр хийх нь одоохондоо тодорхой бус байна. Өнөөдөр хөтөлбөр нь үнэ, гарах бүтээгдэхүүний хэмжээний талаар илүү мэдээлэлтэй болсон тул тодорхой бус байсан зарим зүйлсийг цэгцэлж, хамтран ажиллагч талуудад материал нийлүүлэх зарчимаа боловсруулахдаа тогтвортой байдлыг харгалзан уян хатан, ойлгомжтой байхаар төлөвлөнө. Хөтөлбөр нь тэтгэмж хэлбэрийн дэмжлэгээ алгуур бууруулан ажиллана. /Тэр дундаа далд хэлбэрийн тэтгэмжийг хамруулан/

**Арилжааны, нээлттэй харилцаа холбоог дэмжинэ:** Хөтөлбөр нь өнөөгийн байдлаар тоног төхөөрөмж, хор бордоо болон үрийн нийлүүлэлтийг зуучлан ажиллаж байгаа. Цаашид дээрхи бүтээгдэхүүнүүдийн үнийг тогтоож, арилжааны журмаар нийлүүлэх чадвартай хувийн салбарын төлөөлөгчдийг тодорхойлно.

**Төрийн захиргааны нэгжүүдтэй хамтран ажиллах:** Хөтөлбөр нь төрийн яамдуудтай, тэр дундаа гол төлөв ХХААЯ-тай холбоог тогтоон, төмсний салбарт тэтгэмжийг чиглүүлэн, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн төлөөх лобби арга хэмжээг авч явуулна.

## **2.8.Гол оролцогчид**

### **2.8.1.Жижиг үйлдвэрлэгчид**

Хэдийгээр жижиг үйлдвэрлэгчдэд үрийн чанарыг сайжруулах, сайн чанарын үр олж авах бололцоо хязгаарлагдмал байдаг боловч тэдний тоо жилээс жилд өсөж, тодорхой туршлага хуримтлуулсаар байна.

ХХААЯ-аас гаргасан судалгаагаар 2га-аас бага талбайд төмс тариалан амьдарч байгаа 40000 орчим айл өрх байдаг байна. Эдний ихэнх нь гар хөдөлмөрт тулгуурлаж байгаа бөгөөд үрийн чанарыг сайжруулаад, технологийг нь боловсронгуй болговол төмс тариалагчдын тоо цаашид өсөх хандлагатай байгаа юм. Албан ёсоор данслагдаагүй үр үйлдвэрлэгч нар ч энэ бүлэгт хамрагдаж байгаа бөгөөд тэд чанар сайтай үр үйлдвэрлэх бодит бололцоотой, өөрийн гэсэн сорттой, төмс хадгалах зоорь агууламжтай юм. Гэтэл төмсний үр үйлдвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн зарим нь үрийн төмс хадгалах зоорьгүй байгаа юм. Иймээс хөтөлбөрийн гол зорилго нь албан бус үр үйлдвэрлэгчдийг дэмжиж, тэдний хийж буй үйл ажиллагааг албан ёсны болгох, тэдний үйлдвэрлэж байгаа үрийн материалыг хянах, шалгах, энгийн арга, баталгаажуулалтыг нэн тэргүүнд нэвтрүүлэхийг зорилгоо болгож байна. Иймээс чанарыг шалгах энгийн хүртээмжтэй аргад тэднийг сургаснаар тэдгээрийг үйлдвэрлэлдээ тавих хяналтаа сайжруулж, хэрэглэгчдийн итгэлийг олж авахад тустай гэж үзэж байна.

### **2.8.2.Баталгаат үр үйлдвэрлэгчид, төмсний үйлдвэрлэлээр дагнан мэргэшсэн компаниуд**

Одоогоор эрдэм шинжилгээний байгууллагуудаас гадна ХХААЯ-наас төмсний үр үйлдвэрлэл дагнан эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 4 хувийн компани бий. Энэ 4 компани нь төмс үйлдвэрлэлээр дагнан олон жил ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн процесс нь бүрэн механикжсан болно. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн төмс хадгалах зоорь нь Улаанбаатар болон бусад төвлөрсөн газруудад байрладаг. Төмсний үр үйлдвэрлэгчдийн ихэнх хуучирч муудсан Орос техниктэй, хоцрогдсон технологиор үйлдвэрлэлээ хөтөлж байна. Ихэнх техник ашиглалтын хугацаа хэтэрсэн, эвдэрч бүрэн бус ажиллагаатай болсон зэрэг нь гол хүндрэлтэй асуудал болж байна. Албан үр үржүүлэгчид төслийн хүрээнд вирусын өвчнөөс ангижирсан эрүүл үр үйлдвэрлэх бөгөөд хөтөлбөрөөс технологийн шинэчлэл хийх, усалгааны техник төхөөрөмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

### **2.8.3. Орон нутаг дахь зохицуулагчид /аймгийн ерөнхий агрономичид/**

Төслийн 2 дахь шатанд бүх аймгийг хамарсан 200 гаруй албан бус үр үржүүлэгчдийг сонгон ажиллуулна. Дэд бүтэц муутай, алслагдсан бүс нутаг дахь тэдний үйл ажиллагааг зохицуулахад хүндрэл учрах ба үүнийг шийдвэрлэхийн тулд ХУН-аас орон нутаг дахь зохицуулагчдыг сонгон гэрээ байгуулж ажиллаж байна. Тэдний ихэнх нь орон нутгийн нөхцөл, хүмүүсийг сайн мэдэх, технологийн удирдагчид юмуу аймгийн ерөнхий агрономичид байгаа юм.

#### **2.8.4. Борлуулалтын сүлжээний байгууллагууд ба орлого бүрдүүлэгчид**

Хөтөлбөрийн гол үр дүнгийн нэг нь одоогийн оршин тогтнож байгаа үрийн болон хүнсний төмсний зах зээлийн системийг өөрчлөн сайжруулах явдал болно. Одоогоор хүнсний төмсийг зах зээлд борлуулахдаа завсрын шат дамжлаг буюу “ченж” гэж өөрсдийгөө нэрлэгч бүлэг хүмүүсээр дамжуулан өндөр үнээр борлуулж байгаа юм. Иймээс хөтөлбөрийн нэг гол зорилго нь энэ завсрын шат дамжлагыг арилгах замаар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчээс шууд хэрэглэгчид хүргэх арга замыг эрж сүвэгчлэх асуудал мөн.

Төмсийг ялгах дугаарлах, савлах, үйлдвэрийн дамжлага, хадгалах төхөөрөмж бүхий борлуулагч, хэрэглэгчдийн хүчин чадлыг бэхжүүлэх асуудлыг хамтад нь шийдвэрлэхэд дөхөм үзүүлэх явдал мөн чухал. Монгол одоогоор химийн хор, бордооны үйлдвэр байхгүй, түүнийг хангах нэгдсэн систем байхгүй байна. Иймээс хөтөлбөрийн зүгээс ургамал хамгааллын тун, эрдэс бордооны хангалтын оновчтой системийг бүрдүүлэх, эдгээрийг импортлогчдыг хөнгөлөлттэй зээлийн бодлого, татварын бодлогоор дэмжих арга замыг тодорхойлох бодлого барьж байна.

#### **2.8.5.Хөтөлбөрийн шууд бус үр дүн хүртэгчид**

Нийтдээ төмс тариалдаг гэж бүртгэгдсэн өрхийн тоо 37000 байгаа бөгөөд энэ тоо цаашид өсөх юм. Учир нь нэлээд тооны олон нийтийн байгууллагууд хөдөөгийн ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр төсөл хөтөлбөрүүд боловсруулж энэ зорилтыг хэрэгжүүлэх гол үр дүнтэй арга зам нь өрхийн үйлдвэрлэл, жижиг аж ахуйд төмс хүнсний ногоо тариалах явдал гэж үзэж байгаа юм. Тус хөтөлбөрийн хүлээгдэж байгаа гол үр дүн нь Монгол оронд зохицсон сайн сортын өндөр чанартай үрийн хангамжийг сайжруулж, Монгол орны өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч байгаа жижиг үйлдвэрлэгчид, өрхийн тариаланчдыг хангахад оршино. Үрийн чанар сайжруулж, технологийг боловсронгуй болгосноор зах зээлд гаргах бүтээгдэхүүний хэмжээ, чанар, хүрэлцээ нэмэгдэнэ. Энэ нь тариаланчдын шууд орлого ашиг нэмэгдээд зогсохгүй, хэрэглэгчдийн хангамжид шууд бусаар нөлөөлнө гэсэн хэрэг болно. Иймээс Хөтөлбөрийн шууд үр шим хүртэгчид нь төмсний үйлдвэрлэл эрхлэгчид, шууд бус үр шим хүртэгчид нь хэрэглэгчид болно. Хөтөлбөрийн эхний шатанд улсын болон хувийн өмчийн төмс тариалагч, үйлдвэрлэгчдийн ашигт ажиллагаа нэмэгдэх нь дамжиггүй юм. Алслагдсан бүс нутагт байгаа жижиг аж ахуй эрхлэгчид хөтөлбөрт хамрагдсанаар жил бүр сайн чанарын үр олж авах бололцоог олж, энэ утгаараа албан үр үржүүлэгчидтэй адил түвшинд хүрнэ. Гэхдээ 2005 оноос эхэлж байгаа бэсрэг булцууны үйлдвэрлэл нь 2009 он хүртэл элит үр гаргах боломжгүй бөгөөд энэ хугацаанд одоогийн үргэлжилж байгаа үрийн аж ахуйн системд тулгуурлаж, үр үйлдвэрлэлийн шилдэг технологид сургах, аж ахуйн нөхцөлд үр үйлдвэрлэх боломжтой аргуудыг нэвтрүүлэх, үрийг нь сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Мэдлэгийг түгээх бүх төрлийн хэрэгслийг өргөн ашиглана. Энд нийтийн мэдээллийн хэрэгслүүдээс гадна хялбаршуулсан гарын авлага онцгой үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь элит үрийн үйлдвэрлэлээс өмнө тариаланчид технологийн сургалтанд хамрагдаж, технологи болон менежмент нь сайжирснаар одоо авч байгаа ургацаасаа илүү өндөр авах боломжтой болох бөгөөд энэ хэмжээгээр тэдний ашиг орлого нэмэгдэнэ. Үндэсний үйлдвэрлэл

нэмэгдсэнээр импортыг бууруулж, импортоос тодорхой хэмжээний валютыг чөлөөлөх боломжтой болно.

### **2.8.6.Орон нутгийн удирдлага**

Орон нутгийн хөгжлийн удирдлага нь аймгийн болон сумын удирдлагад төвлөрнө. Туршлагаас харж байхад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд тариаланч үйлдвэрлэгчидтэй харилцаа холбоо муутай байдаг, тариалангийн томхон компаниуд гол ажил олгогч, татвар төлөгчийн үүргийг гүйцэтгэдэг. Аймаг, сумын захиргаадад хөдөө аж ахуйн газар, хэлтэстэй бөгөөд тэдгээрээр дамжин бодлогоо хэрэгжүүлж байна. Хөтөлбөрөөс орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажиллахаар тусгагдсан бөгөөд ялангуяа газар ашиглалт, төлөвлөлт, газрын эрх зүйн хүрээнд энэ хамтын ажиллагаа нэлээд хөгжинө. Хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг технологийн сургалтанд хамруулж, албан бус эктейншиний хэлбэрт оруулж, тэднийг сургагч багшаар ажиллуулах юм. Орон нутгийн засаг захиргаанаас газар ашиглалтын эрхийг хамгаалах, усалгаатай талбай олгох, Газрын хуулийн хэрэгжилтийг хангах, энэ хуулийн хүрээнд усалгааны ус ашиглах эрхийг зохицуулна.

### **2.8.7.Төрийн байгууллагууд**

#### **Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам**

ХХААЯ нь хүн амын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бодлого шийдвэрээр зохицуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монгол дахь ШХА байгууллагын гол хамтран ажиллагч гэж үзнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дээрх байгууллагуудын гүйцэтгэх үүргийг дараахь байдлаар томъёолж байна.

- Зохицуулах хорооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад мониторинг хийж, үнэлгээ дэмжлэг үзүүлэх
- Эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, орон нутгийн удирдлага, бодлого боловсруулагчдыг чиглүүлэх, туслах
- Хөтөлбөрийн экспертиз хийх, туслах
- Статистик тоо баримт бусад мэдээллээр хангах
- Шилдэг технологи импортлох, баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх, олон улсын шинжээчидтэй гэрээ контракт байгуулах

#### **Улсын мэргэжлийн хяналтын газар**

Улсын мэргэжлийн хяналтын газар нь төмсний үрийн чанарын баталгаажилтыг хангах гол байгууллага юм. Мэргэжилтэн, улсын байцаагчид нь талбайн болон агуулахын хянан баталгаа хийх, чанарын шинжилгээ хийх зэрэгт оролцох, энэ талаар сургалт явуулах үүрэг хүлээнэ. Түүнчлэн хүнсний болон товарын төмсний стандартуудыг боловсруулах, шинэчлэхэд оролцоно.

### **Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд**

Хөтөлбөр нь ХААИС, түүний харьяа эрдэм шинжилгээний байгууллагуудтай нягт хамтран ажиллана. Эдгээр байгууллагуудын судлаач, мэргэжилтнүүд өөрсдөө сургалтанд хамрагдах, шилдэг технологиудыг эзэмшиж бусдад зааж сургах, сорт сорих, технологийг боловсруулахад оролцоно. Эрдэм шинжилгээний байгууллагууд дараахь асуудлыг хариуцна.

- Төмсний шинэ сортуудын эрүүл үр, бичил булцуу үйлдвэрлэх, цаашид элит болон сортын үрийг гэрээгээр үйлдвэрлэх, үржүүлэх
- Хээрийн туршлага судалгааны үр дүнгээр шаардлагатай параметр, заалтуудыг боловсруулах (тундасны хэмжээ, хөрсний чийг, температур, хог ургамал, өвчин, хортны илэрч, тархац, үрийн чанар гэх мэт)
- Талбайн сургалт, үзүүлэх сургуулиудыг зохион байгуулахад оролцох, туслах

### **2.8.8.Гадаад түншүүд**

Олон улсын төмсний төв (ОУТТ)-ийн техникийн болон судалгааны үр дүнг өргөн ашиглана. Индонезийн Богор хотод байрладаг ОУТТ-ийн бүсийн төвөөс энэ байгууллагын эрдэмтэд, экспертүүдийн ажлыг удирдан зохицуулна. Зүүн Өмнөд болон Зүүн Азийн нөхцөлд дадлагажсан нарийн мэргэжлийн эрдэмтэд төмсний сортууд болон технологийн судалгааг Монгол оронд хөгжүүлэх, судлаач, үйлдвэрлэгчдийн холбоог бэхжүүлэх чиглэлд гол үүрэг гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн бэлтгэл шатанд бичиг баримт боловсруулах, тэргүүний технологийн сургалтууд зохион байгуулах үндэсний мэргэжилтнүүдийг сургахад нарийн мэргэжлийн олон улсын зөвлөхүүд онцгой үүрэг гүйцэтгэнэ.

Түүнээс гадна жижиг үйлдвэрлэгчдийг усалгаанд шилжүүлж, үрийн чанарыг нь сайжруулах замаар төмсний үйлдвэрлэлд ихээхэн амжилт олж байгаа жижиг талбайд төмсний үйлдвэрлэл явуулдаг үйлдвэрлэгчид бүхий Өвөр Монголын улсын болон хувийн судалгааны хүрээлэнгүүд, тэндхийн эрдэмтэн судлаачдыг хөтөлбөрт өргөн оролцуулахаар тусгасан.

### **2.8.9.Иргэний нийгэм**

#### **Дотоодын болон ОУ-ын ТББ-ууд**

Монголд ажиллаж буй хэд хэдэн ТББ-ууд ядуурлыг бууруулах ба хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажилладаг. Тэдний ихэнх нь хүнсний ногоо тариалах нь хүнс үйлдвэрлэх аж ахуй эрхлэх, орлого нэмэгдүүлэх нэг үүсвэр гэж үзэж түүнд дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр байгууллагууд нь сүлжээнд орж, гол үйл ажиллагаануудаа янз бүрийн бүс нутгуудад явуулж байна. Тэдний хөтөлбөрөөс үр дүн хүртэгчид албан бус үр үржүүлэгчдийн түвшинд хамтран ажиллаж нэмэлт орлого олж болох бөгөөд эдгээр ТББ-ын зарим нь өөрийн хөтөлбөрийн хүрээнд үрийн сан байгуулж болох юм.

#### **Хэрэглэгчдийн байгууллагууд**

Монголд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалсан хэд хэдэн байгууллагууд байна. Ялангуяа шинэ сорт сорьж, нутагшуулах үед хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд

нийцсэн шинж чанартай сорт нутагшуулахын тулд эдгээр байгууллагуудын төлөөллийг ТҮЗ-нд оролцуулна.

#### **2.8.10. Монгол дахь ШХА (Швейцарийн Хөгжлийн Агентлаг)**

Санхүүжүүлэгч байгууллагын хувьд ШХА нь хөтөлбөрийн хэрэгжүүлэлт ба удирдлагыг нэгдмэл байдлаар хариуцна. ШХА нь төлөвлөсөн үйл ажиллагаануудыг санхүүжүүлэн зорьсон үр дүнд хүрэх асуудалд хөтөлбөрийн нөөц бололцоог чиглүүлнэ. Хөтөлбөрийг санхүүжилт ба гадаадын мэргэжилтний техник туслалцаа, гадаадын сургалт зэрэг бусад зүйлээр дэмжинэ. Хэрэгжүүлэгчийн ажлыг шууд удирдахын зэрэгцээ үйл ажиллагаа, санхүүжилтийн хувьд хянаж ажиллана. ШХА нь Швейцарийн хамтын ажиллагааны нэг хэсэг бөгөөд баримт бичигт тусгагдсан хөтөлбөрийн зорилготой зөрчилдсөн аливаа шийдвэр ба дараагийн тайлан, үнэлгээг хориглох эрхтэй байна. Хэрэгжүүлэгч байгууллага нь жил бүр ШХА-ийн зөвшөөрсөн гадны аудитын байгууллагаар санхүүгийн хяналт хийлгэнэ. Хэрэгжүүлэгч байгууллагын гадаад харилцаанд туслалцаа үзүүлэн техникийн туслалцаа хэлбэрээр гадаадын сургалтанд оролцуулах, хөрөнгө мөнгөний асуудалд тусална. Хэрэгжүүлэгчийн ажлыг удирдлагаар хангаж, үйл ажиллагаа болон санхүүгийн мониторингийг хариуцна.

#### **2.9. Төслийн хугацаа, газарзүйн онцлог**

Төслийн 2-р үе шат нь 2008 оны 1-р сараас 2011 оны 12-р сар хүртэл үргэлжилнэ.

Үр үйлдвэрлэх үйл ажиллагаанд улс орныг нийтэд нь хамруулах зорилго тавина. Төмсний үйлдвэрлэлийн 80% нь газар тариалангийн төвийн бүсийн цөөн аймагт төвлөрч байгаа бөгөөд үр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө газарзүйн энэ байрлалын дагуу явагдаж байна.

Үрийн хэрэглээний хүрээг тогтоохдоо тохирох түншүүдийн байрлаж байгаа сонгогдсон газар нутгуудад хэрэгжүүлэхээр бодолцов.

Төмсний үйлдвэрлэлийн аргыг сайжруулахад үүнтэй төстэй хандлагыг чиглэл болгов.

Монгол орны баруун бүс нутаг нь ядуурлын халуун цэг, ШХА-ийн Монгол дахь стратегийн дагуу нэн тэргүүний анхаарал хандуулах бүс нутаг болох тул энэ бүс нутагт хөтөлбөрийн анхаарал чиглэгдэж, тэнд үйл ажиллагаа явуулж буй түншүүдэд түшиглэн ажиллах бодлого баримтална. Гэхдээ зөвхөн баруун бүс нутагт ажиллаж буй түншүүдэд гол анхаарал хандуулж ажиллана гэвэл учир дутагдалтай болно. Харин баруун болон төвийн бүс нутгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа түншүүдэд түшиглэн жижиг фермерүүдтэй хэсэгчлэн хамтарч ажиллана.

Хамгийн боломжтой түнш аймгууд болон ОУБ-ын бусад төслүүд хэрэгжиж буй түншлэлийн бүсүүдэд:

- Завхан Баянхонгор аймаг дахь ADRA
- Увс, Говь-Алтай дахь Дэлхийн Зөн ОУБ
- Баян-Өлгий дэх Францын Action contre la faim: төсөл
- Улаанбаатар дахь Эмэгтэй фермерүүдийн холбоо зэрэг орно.

Эдгээр байгууллагуудтай түншлэлийн зарчим дээр хамтран нэг зорилгоор хамтарч ажиллана

Хот суурин газрын боруулалтын сүлжээ нь Улаанбаатарт төвлөрөх бөгөөд орон нутаг дахь зорилтот бүлгүүдийн сүлжээ нь төв болон баруун бүсэд төвлөрч хийгдэнэ.

### 3.Эрсдэл ба таамаглал

Төсөлд учирч болох хамгийн том эрсдэл нь менежмент болон Зохицуулах байгууллагын үйл ажиллагааны доголдол юм.

Шинээр 2 ажилтан авч, төслийн ажилтнуудын тоог нэмэгдүүлсэн бөгөөд цаашид ч ажилтан нэмж авах шаардлага байгаа учраас төслийн удирдлага тодорхой чиглэл, зохицуулалттай байх нь чухал юм.

Төслийн болон менежментийн бүтээгдэхүүнд хийх мониторингийн шинжилгээ чухал үүрэгтэй бөгөөд үр дүнд боловсруулж буй мониторингийг бэхжүүлэх арга хэмжээг тусгасан байна.

"Чухал таамаглал"-д хамаарах цаашдын эрсдлийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд доорх байдлаар тусгасан:

1. Төмсний хэрэглээ нь хүрэлцээ, хангалтын сүлжээний сайжруулалтанд тохирохоор байж чадахгүй байж болно. Энэ нь эрэлт хэрэгцээ нэмэгдээгүй байхад үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр үнийн уналтыг бий болгож болзошгүй. Тиймээс төслөөс эрсдлийн шинжилгээг тогтмол хийж байх шаардлагыг бий болгож байна.
2. Бусад гадаад хүчин зүйлээс шалтгаалж төмсний үнэ огцом унаж (>30%) магадгүй (хямд импорт г.м).
3. Хэрэв 2008-2011 онд байгалийн гамшиг дундаж хэмжээнээсээ олон дахин тохиолдвол, төсөл болон салбарын үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх процесс тасалдаж, ноцтой саад учруулна. Ялангуяа үрийн ургац алдсанаар үрийн хангалт үе шат бүртээ саатаж болно. Гэхдээ услалтын системийг сайжруулж, үрийн үйлдвэрлэлийг төвлөрлөөс гаргаснаар эрсдлийг бууруулж болох юм.

#### Үр

4. Засгийн газрын бодлого, институци нь энгийн, хүнд сурталгүй чанарын хяналтын тогтолцоотой байх нь бараг боломжгүй. Тиймээс чанарын хяналтын системийг ялгавартай боловсруулах арга замыг судалж үзэх нь эрсдлийг бууруулахад шийдвэрлэх үүрэгтэй.
5. Ихэнх фермерүүдийн хувьд чанар сайтай үрийг өндөр үнээр авч тариалах нь ашиггүй байж болно. Тэд шинэ сортыг аваад өртөг хэмнэхийн тулд өөрсдөө үржүүлэх сонирхолтой байдаг. Энэ тохиолдолд үрийн үйлдвэрлэл эрэлт хэрэгцээг хурдан хугацаанд хангаж чадах юм. Иймээс холбогдох судалгаа (Фермерүүд чанартай үрийг хэрхэн ашиглаж байгаа, фермерүүдийн өөрсдийн үртэй харьцуулбал цэвэр үрийн давуу талууд зэрэг)-г төлөвлөн зохион байгуулж, уг судалгааны үр дүнгээс хамаарч үрийн схемд өөрчлөлт оруулах боломжтой

6. Үрийг дахин эргэлтэнд оруулах нь төслийн үрийн нэр хүндийг бууруулахад хүргэж болно: Фермерүүдээс буцаан авч байгаа үр нь чанарын хувьд янз бүр байх учраас зарим нэг худалдан авагчид сэтгэл дундуур байж болно. Тиймээс төслөөс буцааж авч буй үрийн чанарт мониторинг хийж, шаардлагатай бол тухайн үрийг дахин эргэлтэнд оруулахыг зогсоох хүртэл арга хэмжээ авна.
7. Төсөл нь зөвхөн жижиг фермерүүдэд анхаарлаа хандуулбал том фермерүүд төслийг сонирхохоо больж магадгүй. Тиймээс төсөл нь ялгаатай бүлгүүдэд тохирсон тэнцвэртэй анхаарал хандуулах асуудлыг анхаарах ёстой.

#### **Үйлдвэрлэлийн аргыг сайжруулах**

8. Түншүүд нь жижиг фермерүүдийн хүчин чадал, бэрхшээл зовлонг төдийлөн мэдэхгүй, мэдрэмж, санаачлагатай ажиллаж чадахгүй байж болно. Үлгэр жишээ ферм, нийтийг хамарсан зөвлөмжийн талаарх санаа тэдэнд дутагдсан байдал ажиглагдаж болно. Оролцооны аргад тулгуурласан хамтын судалгаа шинжилгээ, сургалт нь эрдслийг бууруулахад онцгой ач холбогдолтой.
9. Засгийн газар, банкууд нь хөрөнгө оруулалтын зээлийн талаар зөвшилцөлд хүрч чадахгүй байж болно. Энэ нь механикжуулалтыг тэлэх судалгаа шинжилгээний ажил явуулах бололцоог хааж, үйл ажиллагаа зогсоход хүргэнэ.

#### **Хангалтын сүлжээг сайжруулах**

10. Хангалтын сүлжээнд оролцогч талууд нь хамтарч ажиллахад бэлэн биш байж болно (хоорондоо болон төсөлтэй). Эхний үед хүмүүс мэдээлэл солилцох дургүй байх нь элбэг тохиолддог. Бүх талууд хамтын ажиллагаагаа сайжруулж, мэдээлэл солилцдог болох нь маш чухал юм.
11. Шинэ бүтээгдэхүүний сурталчилгаа, шошго, савлагаа зэрэгт нэмэгдэл зардал гарах учраас үүнийг дагаад үнэ нь өндөрсөж, хэрэглэгчид нь шинэ сортыг худалдан авахаас татгалзаж болно. Үүн дээр болгоомжтой судалгаа явуулж, иймэрхүү дутагдлыг багасгахын тулд борлуулалтанд хяналт тавих шаардлага гарна.
12. Үнэ нэмэгдүүлэх бодит шалтгаан байхгүй байж болно.

#### **Зохистой бодлого, нөхцөл**

13. Оролцогч талууд нь хамтарч ажиллахад бэлэн биш байж болно. Тэд Төмсний Үндэсний Зөвлөлийн ач холбогдолыг ойлгохгүй байж болно. Иймээс төслийн зүгээс гишүүдэд ашиг тус, ач холбогдлыг ойлгуулах нь чухал юм.
14. Үүнтэй холбоотойгоор Зөвлөлийг санхүүжүүлэх асуудал гарч ирнэ. Зөвлөлийг санхүүжүүлэх тогтвортой арга зам олох нь төвөгтэй асуудал биш бөгөөд (гишүүнчлэлийн хураамж г.м) хэрэв зөвлөлийн гишүүд ямар нэг урамшуулал авч байвал идэвх нь сайжирна. Санхүүжүүлэх шинэ санаа сэдэж олох шаардлага өндөр байна.

**Менежмент**

15.Төслийн ажилтнуудын тоо нэмэгдэж байгаа учраас төслийн удирдлагын хувьд ачааллыг зохицуулахад хүндрэлтэй болж болзошгүй.

Тийм учраас менежментийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд менежментийн ур чадварыг аль болох түргэн хугацаанд сайжруулах/шинэчлэх шаардлагатай.

**4. Төгсгөлийн үе шатны стратеги**

Төгсгөлийн 2 жилийн үе шат (2012-2013)-ыг багасгасан төсөвтэйгээр хэрэгжүүлнэ.

Гэсэн хэдий ч 2-р үе шатны үеэс энэ шатны бэлтгэл арга хэмжээ авч эхлэх нь чухал юм. Үүнд дараах арга хэмжээг хамруулж болно:

- Орон нутгийн байгууллага, холбогдох үйл ажиллагааны чадавхийг хөгжүүлэх талаар тууштай мэрийж ажиллах
- Түншүүдийн болон үрийн аж ахуйн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, хуримтлуулсан туршлага, сургамжийг бодитойгоор үнэлэх, давтахгүй байх
- ХУН-ийн менежментийг чадавхийг бэхжүүлж, төслөө бүрэн хэмжээгээр авч явах чадвартай нэгж болгон хөгжүүлнэ.
- Өмчлөлийг өргөтгөхийн тулд шинэ оролцогч талуудыг (ТББ-ууд, борлуулалтын сүлжээнд оролцогчид) шинээр элсүүлнэ.
- Татаасыг аажмаар бууруулах
- Үйлдвэлэлийн орц материалаар хангах ажлыг арилжааны горимд шилжүүлэх
- Хувийн секторыг оролцуулах (Төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, орц материалаар хангах)
- Зохицуулах хороог бэхжүүлэх, ТҮЗ-ийг байгуулах
- ТҮЗ-ийг санхүүжүүлэх тогтвортой арга замыг нээн илрүүлэх

**5. Төслийн зохион байгуулалт ба менежмент****5.1. Гэрээ**

Монгол дахь ШХА нь төслийг хэрэгжүүлэгч байгууллага болох МХШТФХ-той хэрэгжүүлэлтийн гэрээгээ шинэчилж, төслийн саналыг батална.

ХХААЯ-ны харъяа Зээл, тусламжийн бодлого, зохицуулалтын хэлтэс, ШХА-ийн Төв байгууллага нь Швейцарь, Монголын хоорондын хамтын ажиллагааны гэрээн дээр үндэслэн төслийн 2-р үе шатыг батлах гэрээнд гарын үсэг зурна.

ШХА-ийн Төв байгууллага нь олон улсын зөвлөхүүдийн гэрээний асуудлыг хариуцна.

## 5.2. Зохицуулах хороо

Төслийг үр дүнтэй харилцан уялдуулах ба зохицуулах зорилгоор Зохицуулах хороог байгуулсан Энэ хорооны гол зорилго нь төслийн зохицуулалт ба хяналт, үнэлгээг хариуцан явуулах үүрэгтэй.

Зохицуулах хороо нь жилд доод тал нь нэг удаа хуралдана. ШХА-ийн удирдлага нь нэмэлт хуралдааныг санал болгож болно. Холбогдох бүх оролцогч талуудын төлөөллийг оролцуулснаар Зохицуулах хороо нь бүтцийн хувьд өргөжинө.

Хороо нь 10-12 гишүүнтэй байх ба тодорхой асуудлаар хуралдаанд шаардлагатай хүнийг урьж оролцуулж болно. Хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөл уг хуралдаанд тогтмол оролцоно.

Хорооны дарга нь Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамны Стратеги, Бодлого Төлөвлөлтийн Хэлтсийн дарга байх ба хурлын протоколыг түүний нарийн бичгийн дарга анал өгөх эрхгүй гишүүнээр оролцож хөтөлнө. Бусад үед нарийн бичгийн даргын ажлыг ХУН-аас хийнэ. Протоколын холбогдох мэдээлэл донорууд, оролцогч талуудад нээлттэй байна. Хэрэгжүүлэгч байгууллага болон ХУН-ээс тус бүр нэг төлөөлөгч хурал бүрд санал өгөх эрхгүй гишүүнээр оролцоно.

### Гишүүд:

- Холбогдох яам, агентлаг, байгууллагын төлөөлөл (2)
- Орон нутгийн засаг захиргааны төлөөлөл (1)
- Монгол дахь ШХА-ийн төлөөлөл (1)
- Төмс тариалагч, ТББ, ЭШБ-ын төлөөлөл (3)

### Урилгаар оролцуулах

- Хэрэгжүүлэгч байгууллага, ТУН-ы төлөөлөл (тус бүр 1 )
- Шаардлагатай бол өөр мэргэжилтэн, нөөц боловсон хүчний төлөөлөл

### Зохицуулах Хорооны гол үүргүүд

Зохицуулах Хороо нь хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийг Хэрэгжүүлэгч байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг удирдан чиглүүлдэг ба ерөнхий дүрэм, журам боловсруулж, хэрэгжүүлэгчид зөвлөгөө өгдөг. Хорооны дарга нь төмсний салбарт хийгдэж буй үндэсний болон олон улсын үйл ажиллагаануудыг зохицуулах үүднээс ХХААЯ-наас томилогддог.

Хорооны гол үүргүүд нь:


- Бүхий л зохицуулалт ба стратегийн шийдвэр гаргах (бодлогын чиглэл, зохион байгуулалт, зохицуулалт)
- Хөтөлбөрийн баримт бичгийн хүрээнд жилийн төлөвлөгөө ба төсвийг хэлэлцэж батлах
- Жилийн үйл ажиллагааны тайлангуудыг хэлэлцэж батлах ба хэрэв шаардлагатай бол дахин чиглүүлэх
- Монголын засгийн газар ба ШХА-ийг мэдээллээр хангах
- Хөтөлбөрийн үйл явцад хяналт шинжилгээ хийх ба шаардлагатай зөвлөмжүүдийг өгөх


- Хамтрагч байгууллага ба шийдвэр гаргагчдаас дэмжих (санхүүжилт, нөөц бололцоо)
- Бусад хандивлагчид ба засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй харилцан уялдуулах
- Гарсан маргааныг шийдвэрлэх
- Оролцогчдод эрх олгох ба гадны байгууллагаар шинжилгээ хийхээр төлөвлөн үнэлгээ хийлгэх бөгөөд тэдний олж авсан дүгнэлтийг хүлээн авах

### 5.3.Төслийн хэрэгжилт ба менежмент

Төслийг хэрэгжүүлэгч байгууллага МХШТФХ нь Зохицуулах хороотой зөвлөлдсөний үндсэн дээр Хөтөлбөрийн Удирдлагын Нэгжийг томилно. Хэрэв бусад донорууд Монголын Төмсний Хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл ХУН-аар дамжуулан ХХААЯ ба Зохицуулах хорооны эрх мэдэл дор хийж болно. (Зураг 7).

Зураг 7: Төслийн хэрэгжилт





## 6. Мониторинг ба үнэлгээ

### 6.1. Мониторинг

ХУН нь мониторингийг зохион байгуулах ажлыг хариуцна. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүснэгт (Хүснэгт 6)-д тусгасан үзүүлэлтүүд дээр үндэслэн явцын ба үр дүнгийн мониторинг хийнэ.

Үүний тулд ХУН нь үйл ажиллагааны төлөвлөгөөний хүснэгт ("чухал таамаглалууд")-ээс эрсдлийн менежментийн матрицийг зохиож, үе үе шинэчилнэ. 2.6-р хэсэгт дурьдсан "Стратегийн зарчмууд" дээр үндэслэн мониторинг хийх ба төслийн үйл ажиллагаа нь үндсэн зарчимтайгаа тохирч буй эсэхийг шалгах арга хэрэгслийг боловсруулж, түүний дагуу шалгана гэсэн үг юм. Оролцогч талууд нөлөөллийн мониторингийг голлон хариуцаж явуулах боловч ХУН-ээс энэ ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

ХУН нь Зохицуулах хорооны байнгын хуралдаан бүрт мониторингийн тайланг гаргаж өгнө. Зохицуулах хороо нь төслийн үйл ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүнгүүд гарч буй эсэхийг ерөнхийд нь үнэлж, шаардлагатай тохиолдолд чиглүүлэлтийг хийнэ.

Мөн Монгол дахь ШХА нь төслийн баримт бичиг, ШХА-аас боловсруулсан хэрэгжүүлэлтийн стандартын дагуу хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд мониторинг хийнэ.

ШХ-ийн стратегитай уялдаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд гүйцэтгэлийн хүрээнд (Хүснэгт 8) үйл ажиллагааны төлөвлөгөөнд жил бүрийн чухал үйл явдлыг нэмж тусгасан үзүүлэлтүүдийг мониторинг хийхдээ тооцож үзэж байх шаардлагатай.

ШХА-ийн стратеги ба төслийн уялдаа холбоог харуулах юм.

ХУН нь явцын мониторингийн холбогдох тайландаа эдгээр чухал үйл явдлуудыг багтаана.

Нөлөөллийн сүлжээний мониторинг (ба үнэлгээ)-ийн шалгуурын шидэт гурвалжин гэсэн бүдүүвчээр тоймлон тодорхойлдог:

Өрхийн түвшин дэх эерэг нөлөөллийн цар хүрээ нь хөдлөнгийн оролцооны чадамж, үүний тогтвортой байдлаар тодорхойлогдоно.

Гурвалжингийн талуудын харьцааг зөв байлгах нь чухал гэж ойлгоно

**Шидэт гурвалжин:**



Нөлөөллийн шалгуур нь дараах байдлаар нарийвчлагдана:

- Ажил олголт (ялгаатай зорилтот бүлгүүдийн төмсний талбайн өөрчлөлт)

- Орлого (Ялгаатай зорилтот бүлгүүдэд тохирсон үр ашигтай үйлдвэрлэлийн арга)
- Хүнсний аюулгүй байдал (өрхийн төмсний тариалан)
- Хүнс тэжээл (ялгаатай зорилтот бүлгүүдийн хоол хүнсэнд өөрчлөлтийг бий болгох төмсний үүрэг)
- Эрх мэдэл олгох (фермерүүд өөрсдөө туршилт хийх, хөгжих чадварыг дэмжих, лоббидох чадварыг дээшлүүлэх)
- Нийгмийн нөлөө ба жендерийн тэгш байдал (үйлдвэрлэл, ажлын ачлаалалд өөрчлөлт оруулах)
- Байгаль орчны нөлөө (гадны нийлүүлэлт, энергийн хэрэглээг багасгах)

## **6.2. Үнэлгээ**

Төсөл нь жил бүр дотоод үнэлгээ (жишээлбэл SWOT-ийн дүн шинжилгээ) хийж, жил бүрийн мониторингийн тайланд үр дүнг бичиж баримтжуулна.

2010 оны ургалтын хугацаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, хураангуй бичиг баримтанд мониторингийн тоон мэдээний боловсруулалт хийнэ.

Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний заалт бүрт дээр дурьдсан нөлөөллийн сүлжээн дээр үндэслэн дүгнэлт өгөх явдал нь хөтөлбөрийн явцыг зөв залан удирдах үндсэн нөхцөл болно.

Хөндлөнгийн үнэлгээ нь үрийн хангалтын системийн тогтвортой байдал, судалгаа шинжилгээн дээр үндэслэнэ.

**Хүснэгт 8: Гүйцэтгэлийн хүрээ: Төсөл ба Швейцарийн Хамтын ажиллагааны 2007-2012 оны Монгол дахь стратегийн хоорондын холбоо**

| Үр дүн   |      | Чухал үйл ажиллагаа  | Нотолгоо   | Таамаглал | ШХА-ийн түвшин дэх үр дүнгийн хамаарал* |
|--|------|--|--|-----------|---|
| <b>1.</b><br>Орон нутгийн нөхцөлд дасан зохицсон төмсний сортуудын өндөр, тогтвортой чанартай үрийг үйлдвэрлэж, Монгол орны төмс тариалагчдад хуваарилан тараана             | 2008 | 2007 оны өртөгөөр 200,000 бэсрэг булцуу үйлдвэрлэх   | Төслийн 2008 оны жилийн тайлан   |           | <b>2.1 Үр</b>                           |
|  | 2009 | Үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдээс дэмжигдсэн хангалттай хэмжээний үр үйлдвэрлэх уялдаатай тогтолцоо | Мэргэжилтнүүдийн санал, дүгнэлт (2009 оны төслийн жилийн тайлан )            |           |   |
|  | 2010 | Эмзэг бүлгийн ихэнх тариалагчид чанартай үр хэрэглэх боломж, баталгаа бүрдэнэ                                | Эмзэг бүлгийнхэнтэй ажиллаж буй төслийн түншүүдийн тайлан                    |           |   |
|  | 2011 | Төмсний нийт тариалангийн талбайн 30%-д 2004 оноос хойш нутагшуулсан сортуудыг тариална                      | 2011 оны төслийн жилийн тайлан (аймгуудын статистик мэдээн дээр үндэслэн)    |           |   |
| <b>2:</b><br>Төмс тариалагчдын эдийн засгийн өндөр үр ашиг, чадавхийг нэмэгдүүлэх, оновчтой арга технологийн зохистой хувилбарыг оролцооны аргаар судалж тогтоон дэлгэрүүлэх | 2008 | Эмзэг бүлгийн төмс тариалагчидтай ажиллаж байгаа түншүүдтэй гэрээ байгуулна                                  | Төслийн 2008 оны жилийн тайлан<br>Хамтын ажиллагааны гэрээ                   |           | <b>3.1 Борлуулалтын сүлжээ</b>          |
|  | 2009 | Фермерүүдтэй хамтарч ирээдүйтэй сонголтуудыг тодорхойлно   | Түншүүдийн тайлан  |           |   |
|  | 2010 | Хамтран ажилладаг фермерүүдийн 50% нь дор хаяж нэг эзэмшсэн аргаа хэрэглэнэ                                  | Түншүүдийн нөлөөллийн мониторингийн тайлан (Төслийн 2010 оны жилийн тайлан ) |           |   |
|  | 2011 | Төмс тариалагчдийн 20% нь доод тал нь нэг аргыг эзэмшинэ   | 2011 оны тохиолдлын сонголтоор хийгдсэн судалгаа                             |           |   |

|   |      |   |  |  |                                |
|---|------|---|--|--|--------------------------------|
| <b>3:</b><br>Төмсний хангалтын сүлжээг сайжруулж, орлого нэмэгдүүлэх сонголтыг бий болгоно  | 2008 | Төмсний хоол хүнсэн дэхь үүргийг тодорхойлно                  | Түншүүдийн судалгааны тайлан<br>Суурь судалгаа     |  | <b>3.1 Борлуулалтын сүлжээ</b> |
|   | 2009 | Борлуулалтын сүлжээг сайжруулах ирээдүйтэй сонголтуудыг хийнэ | Түншүүдийн тайлан (Төслийн 2009 оны жилийн тайлан) |  |                                |
|   | 2010 | Хэрэгцээг 30%-аар нэмэгдүүлэх чадавхийг судална               | Үрийн мэргэжилтний бие даасан үнэлгээ              |  |                                |
|   | 2011 | Төмсний хэрэглээ хөдөөд 30%, хот суурин газарт 10% болно      | 2011 оны үнэлгээ                                   |  |                                |
| <b>4:</b> Төслийн зохимжтой хамрах хүрээ, бодлогыг боловсруулж, зөвшилцөхийн тулд гол оролцогч талууд нь хамтын ажиллагаа, хүчин чадлаа нэмэгдүүлнэ | 2008 | Салбарын бүх оролцогч талууд Зохицуулах зөвлөлд орно          | 2008 оны Зохицуулах зөвлөлийн протокол             |  | <b>1.3 Бодлого</b>             |
|   | 2009 | Үр ашиггүй байдлыг олж илрүүлнэ                               | Зохицуулах зөвлөлийн судалгаа                      |  |                                |
|   | 2010 | Гол бодлогыг сайжруулах                                       | Хэвлэл, төслийн тайлан                             |  |                                |
|   | 2011 | ТҮЗ байгуулагдана   | Үндсэн бичиг баримт                                |  |                                |

**\*Төслийн стратегийн хүрээ ( 2007-2012 оны ШХ-ийн стратеги) нь Төмсний төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан дараах "ШХА-ийн оруулах хувь нэмэр"-ийг бий болгоно**

**1.3:** Үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагууд бодлого, журмыг үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхийг бэхжүүлэх, олон янзын оролцогч талуудыг хооронд нь зуучлана → **Бодлого**

**2.1:** Бэлчээрийг сайжруулах, олборлолтын талбайд нөхөн сэргээлт хийх, хөдөө аж ахуй үйлдвэрлэлд зориулж чанартай үрээр ханга оновчтой тариалах технологийг нэвтрүүлнэ **үр ба технологи**

**3.1:** Үйлдэрлэлд орон нутгийн нөөцийн чанар, үйлчилгээ, ур чадварыг сайжруулж, үнэ нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөхүйц чанартай бүтээгдэхүүнийг гаргана → **борлуулалтын сүлжээ**

## **7.Түншүүдийн хувь нэмэр, төслийн төсөв**

---

### **7.1.Үндэсний дотоод нөөц бололцоо ба түншүүдийн оруулах хувь нэмэр**

Төмс тариалагчид, тэдгээрийн ашиг сонирхлын байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, их сургуулиуд, холбогдох агентлагууд, хувийн компаниуд, хамтрагч ТББ-ууд, ШХА зэрэг өөр өөр ангилалд хамаарагдах оролцогч талууд нь төсөлд харилцан адилгүй арга замаар хувь нэмрээ оруулна.

#### **7.1.1. Улсын салбар**

Улсын түншүүд нь (Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, эрдэм шинжилгээний байгууллагууд, их сургуулиуд, холбогдох газар, хэлтсүүд) нь төслийн эдгээр байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу шаардлагатай боловсон хүчний нөөцөөр хангана.

#### **ХХААЯ**

ХХААЯ нь төслийн гол зохицуулагч байгууллага бөгөөд төслийн Зохицуулах хорооны даргыг томилно. ХХААЯ нь ХУН-ыг ажлын байраар хангана. ХХААЯ нь төмсний үр үржүүлэгчдийг Японы санхүүжилтээр хэрэгжиж байгаа холбогдох төсөлд хамруулж, усалгааны тоног төхөөрөмжөө шинэчлэхэд анхаарал хандуулж ажиллана.

#### **УМХГ**

Төмсний үр үржүүлгийн талбай, үрийн чанарын хяналт, магадлагаа, лабораторийн шинжилгээг УМХГ-тай хамтран гүйцэтгэнэ. Үрийн болон хүнсний төмсний стандартууд, хяналт, шинжилгээний арга зүй, стандартыг боловсруулахад хувь нэмэр оруулна.

#### **УГТСЭШХ , УХЭШХ**

УГТСЭШХ, УХЭШХ-үүд нь in-vitro үржүүлэг, серологийн тест, хүлэмжин дэх бэсрэг-булцууны үйлдвэрлэлийн чиглэлээр хүчин чадлыг бий болгож хүмүүсийг сургасан. Төсөлд оролцох хүрээлэнгүүд одоогийн байгаа хүчин чадал нөөцөө ашигласнаар төсөл тавигдсан зорилгодоо хүрч амжилт олоход чухал хувь нэмэр оруулж чадна. Төсөл нь уг хоёр хүрээлэнтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана. Төслийн барьж буй гол стратеги нь хөрөнгө оруулалт хийж, ажилтнуудын чадавхийг хөгжүүлэхэд тус дэм үзүүлэх явдал юм. Бэсрэг булцууны үйлдвэрлэлийн урсгал зардлыг цаашид хүрээлэнгүүд өөрсдөө санхүүжүүлэх шаардлагатай.

## **ХААИС**

ХААИС нь өнгөрсөн жилүүдэд төмсний үйлдвэрлэлийн олон асуудалд ялангуяа ургамал хамгаалал, усалгаа ба бордооны асуудлаар чухал хувь нэмэр оруулсан. Янз бүрийн хүрээлэнгүүдийн экспертүүд хөтөлбөрт оролцох болно. Орчин үеийн ургамал хамгаалах аргууд ялангуяа органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр чадавхийг бэхжүүлэх хэрэгтэй.

### **7.1.2.Хувийн салбар**

Монгол улсын Засгийн газар нь 4 хувийн компанийг төмсний үр үржүүлэгчээр батламжилсан бөгөөд эдгээр нь албан ёсны лицензтэй үр үржүүлэгч юм.

Мөн төсөл нь олон албан бус үржүүлэгчидтэй Хувийн Секторын Оролцооны гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж байгаа бөгөөд цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үргэлжүүлэх юм.

Төсөл нь үрээр хангах, тусгай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, оновчтой технологийн талаар сургалт явуулахад хувь нэмрээ оруулах бөгөөд төмс тариалагчид тариалах урсгал зардал, ургамал хамгаалал, зоорь/хадгалалтын зардлаа өөрсдөө хариуцахаар харилцан тохиролцож гэрээ байгуулна.

### **7.1.3. Иргэний нийгэм**

Монголын газар тариалангийн салбарын хөгжлийг дэмжих зорилготой хэд хэдэн ТББ-иуд ажилладаг. Эдгээр байгууллагууд нь үрийн хэрэглээний стратеги боловсруулах, жижиг фермерүүдэд зориулсан бусад технологийг нэвтрүүлэхэд төсөлтэй хамтран ажиллах боломжтой.

Төсөл нь эдгээр байгууллагуудтай хамтарч ажиллах гэрээ байгуулж, үйл ажиллагаа тус бүр дээр хамтарсан юмуу захиалгаар хийгдсэн нарийвчилсан судалгаа шинжилгээний протокол хөтөлнө.

### **7.1.4. ШХА-ийн хувь нэмэр**

Швейцарийн оруулах хувь нэмэр нь хөтөлбөрийн санхүүжилтээр дамжин хийгдэнэ.

ШХА нь хэрэгжүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн дагуу төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны болон захиргааны зардлын мөнгөн санг гарган өгнө.

ШХА нь олон улсын зөвлөхийн үйлчилгээний зардлыг гаргана. Мөн төслийн үйл ажиллагаанд мониторинг хийж чиглүүлэх, удирдлагын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

### **7.1.5.Бусад доноруудтай хамтран ажиллах**

Төсөл нь өртөг/зардлыг хуваахын тулд бусад донор төслүүдтэй хамтран санхүүжүүлэх механизм хэрэглэх чиглэлээр хамтран ажиллана.

ХУН нь бусад доноруудад санхүүжүүлэх, мөнгөн бус хувь нэмэр, шинэ технологи, нөү-хау-д нэгдэн орох нээлттэй механизмыг бий болгоно.

## 7.2. Төслийн төсөв

Төслийн 2-р үе (2008– 2011 оны) шатны нийт төсөв нь 4302,000 швейцарь франк байна. Төсөв нь (1-4)-р үр дүнд хүрэхэд чиглэгдсэн болон менежментийн (5) үйл ажиллагааг санхүүжүүлэх зардлуудыг багтааж байна.

ШХА-аас санхүүжүүлэх нийт төсөв (швейцарь франкаар) доорх хүснэгтэнд үзүүлэв. Нарийвчилсан төсвийг Хавсралт 1- үзүүлсэн болно.

### Хүснэгт 9. ШХА-аас санхүүжүүлэх нийт төсөв (хавсралт 1-д нарийвчлан дурьдсан) 1000 швейцарь франкаар

| Үр дүн                              | 20          | 20          | 20          | 20         |
|-------------------------------------|-------------|-------------|-------------|------------|
| 1. Үр ба сорт                       | 535         | 588         | 550         | 280        |
| 2. Үйлдвэрлэлийн сайжруулсан аргууд | 166         | 186         | 165         | 160        |
| 3. Борлуулалтын сайжруулсан сүлжээ  | 99          | 77          | 112         | 52         |
| 4. Оновчтой бодлого, нөхцөл         | 3           | 10          | 10          | 5          |
| 5. Менежмент                        | 343         | 322         | 319         | 320        |
|                                     | <b>1146</b> | <b>1183</b> | <b>1156</b> | <b>817</b> |

**Нийт дүн 4302,000 швейцарь франк**